

ГУРВАН ТАЛТ ЗӨВЛӨЛ БАЙГУУЛАХТАЙ ХОЛБООТОЙ ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦЛЫН САНАМЖ БИЧИГ

Энэхүү харилцан ойлголцлын санамж бичгийг (**ХОСБ**) дор дурдсан өдөр дараах талуудын хооронд байгуулсан болно:

1. Ханбогд сум (**Ханбогд сум** гэх);
2. Ханбогд Сумын Багуудын Малчдын төлөөлөгчид (хамтад нь **Малчдын төлөөлөгчид** гэх);
3. Оюу Толгой ХХК (**ОТ**),
(хамтад нь **Талууд**, тусад нь **Тал** гэх).

1. Зорилго

- 1.1 Ханбогд сум, Малчдын төлөөлөгчид болон ОТ-н хооронд гурван талт зөвлөл (**Зөвлөл**) байгуулах зорилгоор Талууд энэхүү ХОСБ-ийг байгуулж байна.
- 1.2 Гурван Талт Зөвлөл нь энэхүү ХОСБ-ийн Хавсралт 1-д хавсаргасан дүрмийг (**Дүрэм**) баталж, түүнд заасан нөхцөлийн дагуу үйл ажиллагаагаа явуулна.
- 1.3 Дүрмээр Зөвлөлийн үйл ажиллагаа, гишүүнчлэл, эрх хэмжээ, шийдвэр гаргах үйл явц болон санхүүжилтийн асуудлыг зохицуулна.

2. Үндэслэл

- 2.1 2012 оны 10-р сард ОТ-н Оюу Толгой Төслийн нөлөөлөлд өртсөн малчид Говийн Газар Шороо болон ОТ Хяналт төрийн бус байгууллагуудын дэмжлэгтэйгээр ОТ-н 2004 оны Нүүлгэн шилжүүлэх гэрээ болон 2011 оны Нөхөн олговрын гэрээтэй холбогдуулан Дэлхийн Банкны Группын харьяа Олон Улсын Санхүүгийн Корпораци, Даатгалын Олон Талт Үйлчилгээний Агентлагийн дэмжлэгтэй хэрэгждэг төсөлтэй холбоотой байгаль орчин, нийгмийн асуудлаар орон нутгийн иргэдийн хүсэлтийн мөрөөр ажилладаг Эрх Зүйн Хяналт, Зөвлөгөө, Омбудсмений Газар (**ЭЗХЗОГ**)-т гомдол гаргасан юм. 2013 оны эхээр Ундайн голын гольдролын өөрчлөлт, Бор Овоогийн задгайг нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой асуудлаар ЭЗХЗОГ-т хандан дахин гомдол гаргасан байдаг (хамтад нь **Гомдлууд** гэх). (Хавсралт 2 – Нэр, гарын үсэггүй гомдлын хувь ЭЗХЗОГ-ийн үнэлгээний тайлангийн хамт)
- 2.2 Багийн хурлуудаас Гомдлуудыг шийдвэрлэхэд оролцох зорилгоор Малчдын төлөөлөгчдийг сонгосон. Малчдын төлөөлөгчид болон ОТ-н хооронд 2013 оноос хойш хэлэлцээ хийгдэж ирсэн бөгөөд үүний үр дүнд тодорхой асуудлуудаар ойлголцолд хүрч, тэдгээрийг биелүүлсэн буюу хэрэгжүүлж байгаа болно.
- 2.3 Түүнчлэн, Ундайн голын гольдролын өөрчлөлт, Бор Овоогийн задгайг нүүлгэн шилжүүлэлтийн нөлөөлөлд хөндлөнгийн шинжээчдийн бүрэлдэхүүн үнэлгээ хийж, зөвлөмжүүд (**Зөвлөмжүүд**)-ийг Талуудад хүргүүлсэн.
- 2.4 Дээрх Зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх зорилгоор болон мөн малчид, бэлчээр, устай холбоотой бусад асуудалд анхаарал хандуулах үүднээс Талууд Зөвлөл байгуулахыг харилцан тохиролцсон болно.

2.5 Зөвлөл байгуулагдсанаар САО-гийн ажиллагаа дуусгавар болохгүй гэж Талууд тохиролцов. Талууд Зөвлөлийн үйл ажиллагаагаар дамжуулан Гомдлуудыг шийдвэрлэхийг хичээнэ. Хэрэв Зөвлөлөөр дамжуулан Гомдлуудыг шийдвэрлээгүй бол малчид Гомдлуудыг шийдвэрлүүлэхээр ЭЗХЗОГ-т үргэлжлүүлэн хандаж болно.

3. Талуудын хүлээх үүрэг

3.1 Тал тус бүр нь:

- 3.1.1 харилцан бие биеэ хүндэтгэж, тэгш эрхтэйгээр хамтран ажиллах;
- 3.1.2 Дүрмийг баталж, үйл ажиллагаандаа дагаж мөрдөх;
- 3.1.3 хүлээсэн үүргийнхээ гүйцэтгэлийн талаар Зөвлөлд тайлагнах;
- 3.1.4 Зөвлөлийн хурлаас гаргасан хүчин төгөлдөр шийдвэрийг биелүүлэх;
- 3.1.5 өөрийн төлөөллийг Зөвлөлд томилон ажиллуулах; түүнчлэн
- 3.1.6 үүргээ ёс зүйтэй, улс төрийн нөлөөллөөс ангид биелүүлэх болно.

3.2 Ханбогд сум нь Зөвлөлийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг ЗДТГ-ын ажилтнууд, Ханбогд сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал болон иргэдэд түгээнэ.

3.3 ОТ нь:

- 3.3.1 Зөвлөлийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг компанийн удирдлага, холбогдох хэлтэс, нэгж, ажилтнуудад мэдээлэх;
- 3.3.2 Зөвлөлийн үйл ажиллагааны үндэслэл бүхий зардлыг Дүрэмд заасны дагуу хариуцах.

3.4 Малчдын төлөөлөл нь:

- 3.4.1 Зөвлөлийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг малчдад түгээх;
- 3.4.2 малчдын гаргасан санал, санаачлагыг нэгтгэж, Зөвлөлөөр хэлэлцүүлэхээр хүргүүлэх.

4. Хамтын Ажиллагааны Гэрээ

4.1 Зөвлөл нь Гомдлыг шийдвэрлэхээс гадна 2015 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр ОТ, Ханбогд сум болон Өмнөговь аймгийн орон нутгийн эрх бүхий байгууллагууд бусад талуудын хамт байгуулсан Хамтын ажиллагааны гэрээ (**Хамтын ажиллагааны гэрээ**)-ний хүрээнд Ажлын Хэсэг хэлбэрээр ажиллахыг Талууд санал нэгтгэйгээр харилцан зөвшөөрөв.

4.2 Талууд дээрх 4.1 дэх хэсэгт заасныг үр дүнтэй хэрэгжүүлэх үүднээс Хамтын ажиллагааны гэрээний дагуу байгуулагдсан Харилцааны хорооны зөвлөмжүүдийн дагуу холбогдох нэмэлт, өөрчлөлтийг Дүрэмд оруулж болно. Хамтын Ажиллагааны Гэрээнд өөрөөр зааснаас үл хамааран Харилцааны Хороо нь Дүрэмд нэмэлт оруулах буюу өөрчлөх эрхгүй. Талууд Харилцааны Хорооноос Дүрэмд оруулахаар санал болгосон нэмэлт буюу өөрчлөлтүүдийг харгалзан үзэх бөгөөд заавал авч хэрэглэх шаардлагагүй.

5. Хүчин төгөлдөр байдал


- 5.1 Энэхүү ХОСБ нь Талууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох ба энэхүү ХОСБ-ийн 5.2 дэх хэсэгт заасны дагуу дуусгавар болох хүртэл хүчин төгөлдөр хэвээр байна.
- 5.2 Талууд дараах зүйлийг санал нэгтгэйгээр зөвшөөрсөн бол Зөвлөл татан буугдаж, энэхүү ХОСБ-ийн хүчин төгөлдөр байдал нэн даруй дуусгавар болно:
 - 5.2.1 Зөвлөлийн зорилго биелэгдсэн; эсвэл
 - 5.2.2 Зөвлөл цаашид байх шаардлагагүй болсон.
- 5.3 Энэхүү ХОСБ болон Дүрэмд заасан нөхцөлүүд хоорондоо зөрчилдвөл Дүрэмд заасан нөхцөлүүд давуу хүчин чадалтай байна.
- 5.4 Талууд санал нэгтэй зөвшөөрснөөр энэхүү ХОСБ-т нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

Талууд зөвшөөрч 2015 оны 6 сарын 8-ны өдөр гарын үсэг зурав:


Ханбогд сумын Малчдыг төлөөлөн:



Лхамдооров овогтой Батцэнгэл ←



Өөлий овогтой Баттогтох ←



Долгорсүрэн овогтой Намсрай ←



Цэвэгдэлгэр овогтой Гүнсмаа ←



Данзаншадав овогтой Наранхүү ←

Ханбогд сумыг төлөөлөн
Ханбогд Сумын Иргэдийн
Төлөөлөгчдийн Хурлын Дарга



Хургаа овогтой Нэхийт
Ханбогд сумын ИТХ-ын дарга ←

Ханбогд сумын Засаг дарга



Таванжин овогтой Буян-Өлзий
Ханбогд сумын Засаг Дарга ←

Оюу Толгой ХХК-ийг төлөөлөн



Шурка овогтой Байгалмаа
Оюу Толгой ХХК-ийн Орон Нутаг, Бүс
Нутгийн Хөгжил, Нийгмийн Харилцаа
хариуцсан Ерөнхий Менежер ←

Хавсралт 1

Ханбогд сум – Оюу Толгой ХХК – Малчдын Төлөөлөгчдийн Гурван Талт Зөвлөлийн Дүрэм

1. Зорилго

1.1. Гурван Талт Зөвлөл (**Зөвлөл**) нь Ханбогд сумын эрх бүхий байгууллага, Оюу Толгой ХХК болон Малчдын төлөөлөгчдийн хооронд 2015 оны 6-р сарын 8 -ны өдөр байгуулсан Харилцан ойлголцлын санамж бичгийн (**Санамж бичиг**) Үндэслэл хэсэгт заасан Эрх Зүйн Хяналт, Зөвлөгөө, Омбудсмений Газар (**ЭЗХЗОГ**)-т гаргасан Гомдлуудтай холбоотой малчид, бэлчээр, ус болон холбогдох бусад асуудал, гомдол, санал санаачлага эсхүл зөвлөмжүүдийг авч үзэх, анхаарал хандуулах, шийдвэрлэх, тэдгээрийн талаар мэдээлэл солилцох, тэдгээрт холбогдуулан санал, зөвлөмжүүд гаргах, түүнийг хэрэгжүүлэх, зохих эрх бүхий байгууллагуудад уламжлах чиг үүрэгтэй болно.

2. Гишүүнчлэл

- 2.1. Зөвлөл нь 15 гишүүнтэй (тус бүр нь **Гишүүн** гэгдэх) байна. Орон нутгийн малчид (**Малчдын төлөөлөгчид**), Ханбогд сум (**Ханбогд сум**) болон Оюу Толгой ХХК (**ОТ**) тус бүр нь Зөвлөлд 5 гишүүнийг тухай бүр томилох эрхтэй.
- 2.2. Гишүүн тус бүр нь 2 жилийн хугацаатайгаар Зөвлөлийн гишүүний үүрэгт ажлыг гүйцэтгэнэ. Тухайн Гишүүнийг томилсон Тал түүний хугацааг сунгаагүй бол (2.6 дах хэсэгт заасан дагуу) 2 жилийн хугацаа дуусгавар болоход тухайн Гишүүний үүрэгт хугацаа шууд дуусгавар болж, тэрээр Гишүүн байхаа болино.
- 2.3. ОТ-ийн Гишүүдийг ОТ-ийн холбогдох эрх бүхий этгээдээс тухай бүр томилж, чөлөөлнө.
- 2.4. Малчдын төлөөлөгчдийн Гишүүдийг Багийн иргэдийн нийтийн хурлын шийдвэрээр тухай бүр томилж, чөлөөлнө.
- 2.5. Ханбогд сумын Гишүүдийг Ханбогд сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал болон Ханбогд сумын Засаг дарга (**Засаг дарга**) нар харилцан зөвшилцсөний үндсэн дээр Засаг даргын захирамжаар тухай бүр томилж, чөлөөлнө.
- 2.6. Малчдын төлөөлөгчид, Ханбогд сум болон ОТ (тус бүр нь **Тал**) тус бүр өөрсдийн томилсон аливаа Гишүүнийг бусад Талуудад бичгээр мэдэгдэл өгсний үндсэн дээр сольж болно. Гишүүнийг сольж буй Тал нь бусад Талуудын зөвшөөрлийг авах шаардлагагүй. Гишүүдийг байнга солих нь Зөвлөлийн ажиллагааг тасалдуулж болзошгүйг харгалзан Гишүүдийг шаардлагагүй, ойр ойрхон орлуулах, солихоос зайлсхийхийн тулд Талууд хүчин чармайлт гаргана.
- 2.7. Гишүүнийг томилж, сольж байгаа Тал нь тухайн томилсон Гишүүн нь Хурал (3.8.1 дэх хэсэгт тодорхойлсончлон) болон Зөвлөлийн ажилд бүрэн оролцох бэлтгэлтэй байхыг хариуцна.
- 2.8. Гишүүд нь Зөвлөлийн хурал дээр хэлэлцсэн асуудал буюу гаргасан шийдвэрийн талаарх мэдээллийг өөрсдийн томилсон Талд цаг тухайд нь дамжуулж байна.
- 2.9. Энэхүү Дүрмийн 2.1-т заасныг үл харгалзан, Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр, Талуудын Гишүүдийн тооны тэнцвэрийг хадгалан гишүүдийн тоог өөрчилж болно.

3. Зөвлөлийн дарга болон Удирдлагын нэгж

- 3.1. Тал тус бүр нь бусад Талуудад бичгээр мэдэгдэх замаар тэргүүлэгч Гишүүн (Тэргүүлэгч гишүүн)-ийг нэр дэвшүүлнэ. Гурван Тэргүүлэгч гишүүн нь Зөвлөлийн удирдлагын нэгж (Удирдлагын нэгж)-ийг бүрдүүлнэ.
- 3.2. Зөвлөлийн дарга (Зөвлөлийн дарга)-ын албан үүргийг ямар ч тохиолдолд Тэргүүлэгч гишүүн гүйцэтгэх ба түүний албан үүргээ гүйцэтгэх хугацаа нь дараалсан 12 сараас илүүгүй эсхүл Талууд өөрөөр тохиролцсон хугацаагаар байна.
- 3.3. Зөвлөлийн даргын албан үүрийг Талууд тус бүрээс тухай бүр нэр дэвшүүлсэн Тэргүүлэгч гишүүд ээлжлэн гүйцэтгэнэ.
- 3.4. Зөвлөлийн анхны дарга нь Малчдын төлөөлөгчдөөс нэр дэвшүүлсэн Тэргүүлэгч гишүүн байна.
- 3.5. Зөвлөлийн дарга нь Удирдлагын нэгжийн бусад гишүүдийн дэмжлэгтэйгээр хурлыг удирдана.
- 3.6. Удирдлагын нэгж нь дараах эрх, үүрэгтэй байна:
 - 3.6.1 хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр Зөвлөлийн хуралд гурван (3) удаа оролцоогүй аливаа Гишүүнийг солих саналыг түүнийг томилсон Талд гаргах;
 - 3.6.2 Гишүүд Зөвлөлийн үйл ажиллагаанд бүрэн мэдээлэлтэй, бэлтгэлтэй, бүрэн оролцох явдлыг хангах;
 - 3.6.3 Зөвлөлийн даргад зөвлөгөө өгөх, туслалцаа үзүүлэх;
 - 3.6.4 Хэлэлцэх асуудлын Жагсаалтанд ороогүй асуудлыг Хурлаар хэлэлцүүлж, шийдвэрлэхийг зөвшөөрөх;
 - 3.6.5 Зөвлөлөөс олон нийтэд ил болгох аливаа мэдээллийг хянаж баталгаажуулах.
- 3.7. Тэргүүлэгч гишүүн тус бүр нь Удирдлагын нэгжийн гаргах аливаа шийдвэрт нэг (1) саналын эрхтэй байх бөгөөд энэхүү Дүрэмд өөрөөр заагаагүй бол Удирдлагын нэгжийн бүхий л шийдвэрийг санал нэгтгэйгээр гаргана.
- 3.8. Зөвлөлийн дарга нь дараах эрх, үүрэгтэй байна. Үүнд:
 - 3.8.1 Зөвлөлийн хурал (ээлжит болон ээлжит бус) (тус бүрдээ **Хурал**)-ыг зарлах, хуралдуулах;
 - 3.8.2 Хурал тус бүр дээр хэлэлцэх асуудлын жагсаалт (**хэлэлцэх асуудлын Жагсаалт**)-ыг Удирдлагын нэгжтэй зөвшилцөж, харилцан тохирох;
 - 3.8.3 Хурал тус бүрийг удирдаж, түүний явцад хяналт тавих;
 - 3.8.4 Хурал тус бүрийн тэмдэглэлийг Гишүүд танилцаж гарын үсэг зурсны дараа аль болох нэн даруй баталгаажуулж гарын үсэг зурах;
 - 3.8.5 Зөвлөлөөр нууцын шинжтэй асуудал хэлэлцэх бол Хурлыг (эсхүл түүний зарим хэсгийг) Гишүүн бус этгээдийн хувьд хаалттай явуулах;
 - 3.8.6 Гишүүн тус бүрт хэлэлцэх асуудлын Жагсаалтыг түүнд заасан асуудлын талаарх мэдээллийн хамт Хурал болохоос ажлын 10 хоногийн өмнө хүргүүлэх;
 - 3.8.7 Зөвлөлөөс олгосон бүрэн эрхийн хүрээнд Зөвлөлийг төлөөлөх.

- 3.9. Хурал эхлэх үед Зөвлөлийн дарга хүрэлцэн ирээгүй бол Гишүүд тухайн Хурлыг даргалах зорилго бүхий Зөвлөлийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийг өөрсдийн дундаас томилно.

4. Шийдвэр гаргах:

- 4.1. (Зөвлөлийн Даргыг оролцуулан) Гишүүн тус бүр Хурлаар шийдвэрлэх асуудал тус бүрээр саналын нэг (1) эрхтэй байна.
- 4.2. Тал тус бүрийн томилсон хамгийн багадаа дөрвөн Гишүүн (өөрөөр хэлбэл нийт 12 Гишүүн) тухайн Хурал эхлэхэд хүрэлцэн ирснээр хурлыг шийдвэр гаргах хүчин төгөлдөрт тооцно (**Хурлын ирц**).
- 4.3. Хурал эхлэх цагаас хойш 30 минутын дараа Хурлын ирц бүрдээгүй бол 48 цагийн дотор Удирдлагын нэгж тохиролцон хурлыг дахин товлоно. Энэ тохиолдолд хэлэлцэх асуудлын Жагсаалтад өөрчлөлт орохгүй. Хэрэв хойшлогдсон Хурлын Ирц хурал эхлэх цагаас хойш 30 минутын дараа бүрдээгүй бол ирсэн Гишүүд хурлын ирц бүрдүүлнэ.
- 4.4. Гишүүдээс саналаа чөлөөтэй өгөх явдлыг хөндөхгүйгээр Зөвлөл нь аль болохоор зөвшилцөлд үндэслэн шийдвэр гаргана. Зөвшилцөлд хүрээгүй асуудлыг дахин нэг удаа боловсруулан хэлэлцүүлж болно. Хэрэв Зөвлөл тийнхүү шийдвэр гаргаж чадаагүй бол шийдвэрийг Хуралд оролцсон саналын эрхтэй Гишүүдийн 75 хувийн саналаар батлах ба ингэхдээ Тал тус бүрийн доод тал нь нэг Гишүүн тухайн асуудлыг дэмжсэн санал өгсөн байх ёстой.
- 4.5. 4.4-д хэрхэн зааснаас үл хамааран Хурал дээр санал хураахаар Зөвлөлөөс дэвшүүлсэн аливаа асуудлаар нэг Талын тухайн Хуралд оролцож буй саналын эрхтэй гишүүд бүгдээрээ эсрэг санал өгвөл Зөвлөл уг асуудлаар ямар нэг шийдвэр гаргахгүй.
- 4.6. Удирдлагын нэгж өөрөөр шийдвэрлээгүй бол санал хураалтыг нээлттэй хурлаар явуулна.
- 4.7. Удирдлагын нэгж өөрөөр шийдвэрлээгүй бол, зөвхөн тухайн хурлын хэлэлцэх асуудлын Жагсаалтад орсон асуудлыг Хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.
- 4.8. Шийдвэрлэгдээгүй асуудлыг Гишүүд болон тэдгээрийг томилсон Талууд хэлэлцсэний үндсэн дээр дараагийн Хурлаар дахин хэлэлцүүлнэ.
- 4.9. Аль ч Тал Зөвлөлийн дүрэм (**Дүрэм**)-д нэмэлт, өөрчлөлт оруулахаар санал гаргаж болно. Харин энэхүү Дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлтийг бүх Талууд санал нэгтгэйгээр баталсан байна.
- 4.10. Зөвлөлийн шийдвэр нь хурлаас батлагдсанаар хүчин төгөлдөр болно. Зөвлөл нь бичгээр тойрох хуудсаар шийдвэр (**Тойрох Шийдвэр**) гаргаж болно. Тойрох Шийдвэр нь Зөвлөлийн бүх Гишүүд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.
- 4.11. Зөвлөлийн шийдвэрүүдийг Хурал тус бүрийн тэмдэглэлд заавал тусгана.

5. Зөвлөлийн бүрэн эрх болон үүргүүд

- 5.1. Зөвлөл нь Гомдлуудыг шийдвэрлэхээс гадна 2015 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр байгуулагдсан Оюу Толгой, Өмнөговь аймаг болон Ханбогд сумын байгуулсан Хамтын ажиллагааны гэрээ (**Хамтын ажиллагааны гэрээ**)-ний хүрээнд байгуулагдсан Харилцааны хорооны Ажлын Хэсэг хэлбэрээр ажиллаж болно..
- 5.2. Шаардлагатай тохиолдолд Зөвлөл нь тусгайлсан асуудлыг хариуцсан ажлын хэсгүүдийг байгуулж болно.

- 5.3. Зөвлөл нь өөрийн зорилго (1 дүгээр зүйлд заасан)-ын хүрээнд, ёс зүйтэй ажиллах бөгөөд бүхий л үед болон улс төрийн нам, улс төрийн сонгуулийн үйл ажиллагаа, олон улсын улс төрийн нөлөөллөөс (аливаа лоббиг оруулан) ангид ажиллана.
- 5.4. Зөвлөл нь дараах үүрэгтэй байна. Үүнд:
- 5.4.1 өөрт олгогдсон бүрэн эрхийн хүрээнд шийдвэр гаргаж ажиллах;
 - 5.4.2 өөрийн зорилгоос (1 дүгээр зүйлд заасан) гадуурх аливаа асуудлаар шийдвэр гаргахгүй байх;
 - 5.4.3 Гишүүнд хариуцуулан хуваарилсан ажил үүргийн жагсаалтыг, ажил тус бүрийн хувьд хэрэгжүүлж дуусгах хугацааны хамт гаргах;
 - 5.4.4 Хуваарилсан ажил үүргийн хэрэгжилтийг хянах, ажил үүрэг тус бүрийн хэрэгжилтийн байдлын талаар олон нийтэд мэдээлж байх.
- 5.5. Зөвлөл нь дараах бүрэн эрхтэй байна. Үүнд:
- 5.5.1 малчид, бэлчээр болон устай холбоотой аливаа асуудал, гомдол, санал, санаачлагын талаар санал, зөвлөмж, шийдвэр гаргах;
 - 5.5.2 аливаа шийдвэрийн зохих хэрэгжилтийг хангах;
 - 5.5.3 Зөвлөл нь аливаа асуудал, гомдол, санал буюу санаачлагад хамаарах асуудлаар шийдвэр, зөвлөмж гаргах эрх бүхий этгээд биш бол Зөвлөлөөс өөр эрх бүхий этгээдээр хэлэлцүүлж шийдвэрлүүлэхээр шилжүүлэх.
- 5.6. Шаардлагатай бол Талууд нь аливаа Хуралд зөвлөх (**Зөвлөх**)-ийн туслалцаатай оролцох эрхтэй байна. Зөвлөхтэй холбоотой аливаа зардал (үүнд аливаа ажлын хөлс эсхүл аяллын зардлыг оруулан)-ыг түүнийг авч ажиллуулж буй Гишүүн эсхүл Тал хариуцна.
- 5.7. Зөвлөх нь Хуралд санал өгөх эрхгүй бөгөөд зөвхөн Зөвлөлийн дарга тусгайлан эрх олгосноор Хуралд үг хэлж болох ба 7.1-р зүйлд заасан Хурлын дэгийг баримтлах ёстой.

6. Харилцаа холбоо болон мэдээлэл солилцох

- 6.1. Хурал дээр хэлэлцсэн хувь хүний нууцтай холбоотойгоос бусад бүх асуудлын талаарх мэдээллийг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олон нийтэд болон Талууд тус бүрийн сонгогчдод мэдээлнэ.
- 6.2. Гишүүд нь Зөвлөлийн үйл ажиллагааны талаар мэдээллийг ил тод, олон нийтэд нээлттэй байлгахыг хичээж ажиллах бөгөөд Зөвлөлийн зөвшөөрснөөр хэвлэл мэдээлэлд өгөх хамтарсан мэдэгдлийг бэлтгэнэ.
- 6.3. Зөвлөлийн үйл ажиллагаатай холбоотойгоор гаргах аливаа хамтарсан мэдэгдэл эсхүл Зөвлөлөөс гаргах хэвлэлийн мэдээний агуулга, хэлбэрийг тийнхүү гаргахаас өмнө Удирдлагын нэгжээр батлуулсан байна.
- 6.4. Зөвлөл нь түүнийг төлөөлөн олон нийт болон хэвлэл мэдээлэлтэй харилцах бүрэн эрхийг Зөвлөлийн аль нэг Гишүүнд олгож болно.
- 6.5. Зөвлөл нь түүний олгосон бүрэн эрхийн хүрээнд ажиллах мэдээллийн нэгжийг байгуулахаар шийдвэрлэж болно.

7. Хурлын дэг

- 7.1. Хурлыг явуулах зорилгоор Зөвлөлийн дарга нь дараах дэгийг баримталж Гишүүд дэгийг ягштал дагаж мөрдөнө:

- 7.1.1 гар утсаа унтраах;
- 7.1.2 гараа өргөж, ээлжлэн ярих;
- 7.1.3 бусдын яриаг таслахгүй байх, бусдыг ярих үед гүйцэд сонсох;
- 7.1.4 бүхий л үед бие биенээ хүндлэх;
- 7.1.5 тухайн Гишүүдийн зөвшөөрөлгүйгээр зураг авах буюу бичлэг хийхгүй байх;
- 7.1.6 орчуулга шаардлагатай үед, орчуулагчид орчуулгаа хийх хангалттай хугацааг олгох;
- 7.1.7 шаардлагатай тохиолдолд өөрийн томилсон Талтай зөвшилцөх үүднээс "завсарлага" авах;
- 7.1.8 Хэлэлцэх асуудлын Жагсаалтад ороогүй аливаа асуудлыг “Асуудлын зогсоол”-д оруулах ба тухайн Хурлыг хаахаас өмнө эсхүл дараагийн Хуралд тэрхүү асуудлыг цаашид хэлэлцэх эсэх эсхүл өөр этгээдэд шилжүүлэх талаар харилцан тохиролцох;
- 7.1.9 Гишүүн бус этгээд нь ажиглагчийн эрхтэйгээр оролцох бөгөөд Удирдлагын нэгжээс зөвшөөрөл авснаас бусад тохиолдолд үг хэлэх буюу санал гаргахгүй;
- 7.1.10 тухайлсан асуудлаар бүх Гишүүд нэгэн зэрэг ижил мэдээлэл авах ба ингэснээр Гишүүд нь мэдээлэлтэй байж асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ;
- 7.1.11 зөвхөн хэлэлцэх асуудлын Жагсаалтад багтсан эсхүл бусад Гишүүд санал болгож Удирдлагын нэгж хэлэлцэхийг зөвшөөрсөн асуудлыг хэлэлцэх.

8. Хурал

- 8.1. Зөвлөлийн дарга нь бусад Тэргүүлэгч гишүүдтэй зөвшилцсөний үндсэн дээр Хурал тус бүрт хэлэлцэх асуудлын Жагсаалтыг эцэслэх бөгөөд Хурал болохоос ажлын 10 хоногийн өмнө Гишүүд тус бүрт бичгээр гаргасан мэдэгдлийн хамт хүргүүлнэ.
- 8.2. Зөвлөл нь 2 сард нэг удаа хуралдах ба шаардлагатай тохиолдолд Удирдлагын нэгжийн хүсэлтээр Зөвлөлийн дарга Хурлыг зарлан хуралдуулна.
- 8.3. Хурлыг боломжтой бол биечлэн оролцох хэлбэрээр хийх боловч бүх Гишүүд зөвшөөрсөн бол аливаа технологи (үүнд утсаар болон дүрсээ харж ярих гэх мэт) ашиглан хийж болно. Зөвлөлийн шийдвэрлэснээр тэрхүү зөвшөөрөл нь тухайн хуралд хүчинтэй байж болно.
- 8.4. Зөвлөлийн дарга Хурал тус бүрийн тэмдэглэлийг Удирдлагын нэгжээс баталсан загварын дагуу хөтлөх, эсхүл Зөвлөлийн Нарийн бичгээр (10.1-р зүйлийг үзнэ үү) эсхүл өөр Гишүүнээр эсхүл ажиглагчаар хөтлүүлэх ба Дүрмийн 4 дүгээр зүйлд заасны дагуу тэмдэглэлийг Гишүүдээр гарын үсэг зуруулна.
- 8.5. Гишүүд нь Хурлын хэлэлцэх асуудлын Жагсаалтад оруулахаар Удирдлагын нэгжид асуудлыг хүргүүлэх бүрэн эрхтэй бөгөөд Удирдлагын нэгж (болон Зөвлөлийн дарга) нь тэрхүү асуудлыг дараагийн Хурлын хэлэлцэх асуудлын Жагсаалтад оруулах эсэхийг шударгаар шийдвэрлэнэ.
- 8.6. Хуралд биечлэн оролцох боломжгүй Гишүүд нь Зөвлөлийн дарга, Зөвлөлийн нарийн бичиг, Удирдлагын нэгжид бичгээр мэдэгдсэний үндсэн дээр өөрийн өмнөөс Хуралд оролцох болон санал өгөх төлөөлөгчийг томилж болно. Гишүүдийг байнга солих нь

Зөвлөлийн ажиллагааг тасалдуулж болзошгүйг харгалзан Гишүүдийг шаардлагагүй, ойр ойрхон оруулах, солихоос зайлсхийхийн тулд Талууд хүчин чармайлт гаргана.

9. Ажиглагчид буюу хөндлөнгийн оролцогчид

- 9.1. Аливаа Гишүүн ажиглагч (**Ажиглагч**)-ийг Хуралд урьж оролцуулах хүсэлтийг гаргаж болох бөгөөд Удирдлагын нэгж санал нэгтгэйгээр зөвшөөрсөн бол Ажиглагч хуралд оролцож болно.
- 9.2. Ажиглагч нь саналын эрхгүй бөгөөд энэхүү Дүрмийн 7 дугаар зүйлд заасан Хурлын дэгийг баримтлана.

10. Зохион байгуулалт болон бусад асуудлууд

- 10.1. Зөвлөлийн нарийн бичгийг (**Зөвлөлийн нарийн бичиг**)-Удирдлагын нэгж санал нэгтгэйгээр томилох ба Зөвлөлийн нарийн бичиг дараах үүрэгтэй байна:
 - 10.1.1. Хурлын хэлэлцэх асуудал, тэмдэглэл болон бусад холбоо харилцаанд дурдсан материалуудыг бэлтгэж (Зөвлөлийн Даргаас эцсийн зөвшөөрөл авснаар) Гишүүдэд болон тэдний хооронд түгээх буюу тэднээс авах;
 - 10.1.2. Зөвлөлийн Хурлыг оролцуулан бүх хурлын тэмдэглэлийг цаасаар болон цахим хэлбэрээр хадгалах;
 - 10.1.3. Зөвлөлийн шийдвэрийн бүртгэл буюу баримт бичиг хөтлөх;
 - 10.1.4. Албан ёсны холбоо харилцаа, гишүүдийн шинэчилсэн бүртгэл болон түүнтэй адилтгах баримт бичиг зэргийг оролцуулан албан бүртгэл хөтлөх;
 - 10.1.5. Бүх Гишүүд ба тэдгээрийг орлогчдын томилгоог хүлээн авч, нягтлан, баталгаажуулж, баримтжуулах;
 - 10.1.6. Зөвлөлийн Дарга, Удирдах Нэгжид зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх;
 - 10.1.7. Зөвлөлийн Дарга, Удирдах Нэгж, Гишүүд энэхүү Дүрэмд заасан үүргээ хэрэгжүүлэхэд туслах бусад шаардлагатай үйл ажиллагааг хийж гүйцэтгэнэ.
 - 10.1.8. Зөвлөлийн нарийн бичиг нь Зөвлөлийн гишүүн бус байна.
- 10.2. Зөвлөл нь чиглүүлэгч (**Чиглүүлэгч**)-тэй байж болно. Чиглүүлэгчийг Удирдлагын нэгж санал нэгтгэйгээр томилно.
- 10.3. Чиглүүлэгч нь дараах эрх, үүрэгтэй байна. Үүнд:
 - 10.3.1. Гишүүдээр Хурлын дэгийг баримтлуулах
 - 10.3.2. төвийг сахиж, аливаа Тал болон Гишүүнд ялгавартай хандахгүй;
 - 10.3.3. Гишүүдийн өмнө нийтлэг тулгамдсан асуудлыг тодорхойлоход туслах, асуудлыг харилцан ашигтай байдлаар шийдвэрлэх хувилбарыг боловсруулахад дэмжлэг үзүүлэх;
 - 10.3.4. яриа, хэлэлцээг асуудалдаа төвлөрсөн байлгах болон явц/хуралд дэмжлэг үзүүлэх;
 - 10.3.5. албан ёсны Хурлын үеэр Гишүүд хоорондоо үр нөлөөтэй харилцахад дэмжлэг үзүүлэх;
 - 10.3.6. Зөвлөлийн оролцож байгаа гэрээ болон зөвлөмжийн төслийг боловсруулахад дэмжлэг үзүүлэх;

- 10.4. Чиглүүлэгч нь Зөвлөл, түүний Гишүүд эсхүл Талуудын хувьд заавал биелүүлэх үүрэг ногдуулсан шийдвэр гаргах эсхүл үр дүн үүсгэх эрхгүй болно.
- 10.5. Хэрэв шаардлагатай бол Зөвлөл нь хөндлөнгийн мэргэжилтнүүдээс сургалт, мэргэжлийн туслалцаа авч болно.
- 10.6. Зөвлөл нь Зөвлөлийн үйл ажиллагаатай холбоотой баримт бичгүүд, хурлын тэмдэглэл, гаргасан шийдвэрүүд зэргийг хадгална. Шаардлагатай бол Гишүүдийн хүсэлтээр, тэдэнд үүргээ хэрэгжүүлэх бололцоо олгохын тулд эдгээр баримт бичгийн хуулбарыг Гишүүдэд өгнө.

11. Санхүүжилт

- 11.1. ОТ нь Зөвлөл болон түүнийн үйл ажиллагаанд өдөр тутмын зохион байгуулалтын дэмжлэг (оффисын хангалт, харилцаа холбоо, мэдээлэл түгээх/хүргэх үйлчилгээ) үзүүлэх үүрэгтэй ба Зөвлөлийн харилцан тохиролцсон, үндэслэл бүхий аялал, сургалттай холбоотой зардлуудыг хариуцна. ОТ нь аливаа Тал Зөвлөх томилох эсхүл гадаадад зорчихтой холбоотой гаргасан аливаа зардлыг хариуцахгүй.
- 11.2. Зөвлөл нь аливаа Гишүүний чадавхийг нэмэгдүүлэхэд чиглэсэн санаачлагыг хэрэгжүүлэх үүднээс хамтран төслийн санал боловсруулах замаар нэмэлт санхүүжилтийн эх үүсвэр олохоор шийдвэрлэж болно.

Зөвлөлийн Гишүүн тус бүр томилогдсоныхоо дараа энэхүү дүрмийг баримталж, дагаж мөрдөхийг зөвшөөрсөн болохыг тэмдэглэх зорилгоор энэхүү Зөвлөлийн Дүрэмд гарын үсэг зурна.

Талууд Зөвлөлийн энэхүү Дүрмийг боловсруулах, батлахад дараах хүмүүсийн оруулсан оролцоо, хувь нэмрийг цохон тэмдэглэж байна. Эдгээр хүмүүс энэхүү Зөвлөлийн Дүрмийг хүлээн зөвшөөрч, түүний зорилго, агуулгыг дэмжиж гарын үсэг зурав.

Хавсралт 2

ЭЗХЗОГ-т гаргасан Гомдлууд, ЭЗХЗОГ-ын Үнэлгээний тайлан

(Дараагийн хуудаснаас)

2012 оны 10 дугаар сарын

Хатагтай Мэйган Тейлор
Нийцлийн Зөвлөх, Эрхийг Хамгаалагч (НЗЭХ)
Олон улсын санхүүгийн корпорац
2121 Pennsylvania Avenue NW
Washington, DC 20433 USA
Fax: (+1) (202) 522-7400
e-mail: cao-compliance@ifc.org

ГОМДОЛ ГАРГАХ НЬ:

Эрхэм хатагтай Тэйлор,

“Говийн газар шороо” ТББ-д нэгдэн зохион байгуулалтанд орсон Ханбогд сумын малчид бид энэхүү гомдлыг Монгол улсын Өмнөговь аймгийн Ханбогд сумын Жавхлант, Гавлиут багуудын нутаг дэвсгэрт орших Рио Тинто, Айвенхоу Майнз, Эрдэнэс МГЛ компаниудын хамтарсан Оюу Толгой ХХК –ний хэрэгжүүлж буй алт-зэс-мөнгө олборлох Оюу Толгой төсөлд холбогдуулан Олон улсын санхүүгийн корпораци (ОУСК)-ийн НЗЭХ танд хандан энэхүү гомдлыг гаргаж байна.

Монгол улсын Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт оршдог Рио Тинто, Эрдэнэс МГЛ ХХК-ийн эзэмшлийн Оюу Толгойн зэс-алтны төсөлд танай ОУСК-иас 900 сая, Олон талт хөрөнгө оруулалтын батлагааны агентлагаас 1 тэрбум орчим америк долларын зээл ба эрсдлийн баталгаа олгох асуудал идэвхтэй судлагдаж байгаа болно.

Бид Өмнөговь аймгийн Ханбогд сумын Жавхлант, Гавлиут багийн Шивээ толгой, Халив, Шавгын бууц, Улаан толгой, Гойн цохионы бууц, Хар хадны дөрвөлж, Зараагийн бууц, Хөндий зараагын бууц, Хүрэн толгойн өвөлжөө, Зүрх салааны өвөлжөө нэртэй газар оршин суудаг. Бид Оюу Толгойн төслийн сөрөг нөлөөлөлд өртөж байгаа бөгөөд төсөл бүрэн хэрэгжиж өргөжих явцад улам гүнзгий өртөх магадлал өндөр байна.

Нүүдэлчин малчид бид ганц нэг айлаар хөдөө зэлүүд нутагт хол хол оршин суудаг учир компани, нутгийн захиргааны элдэв дарамт шахалтаас болгоомжлох шаардлага байдаг тул бидний тухай мэдээллийг нууцлахыг хүсч байна. Мөн алслагдсан нутагт оршин суудаг, харилцаа холбоо тогтмолжоогүй, англи хэлээр шууд харилцах боломжгүйг харгалзан бид энэ гомдлыг Улаанбаатар хотод байршилтай Оюу Толгойн Хяналт ТББ-тай хамтран гаргаж танай байгууллагатай харилцах эхнийг дамжлага байхаар тохирсон болно.

Бидэнтэй дараах хаягаар холбоо барьж болно:

Л. Батцэнгэл, Говийн газар шороо ТББ-ын захирал
Хаяг: Өмнөговь аймаг, Ханбогд сум
Утас: 976-88705595, 976-99608279,
E mail: Tsengel_5595@yahoo.com;

Д. Сүхгэрэл, Оюу Толгойн Хяналт ТББ-ын Гүйцэтгэх захирал
Хаяг: СБД, Бага Тойруу, 44-6
Утас: 976- 99185828, 976- 98905828
Мэйл: otwatch@gmail.com

Төсөл нь өмнийн говийн усны нөөцгүй бүсэд хэрэгжих барилгын шатны ажлыг хэрэгжүүлж байгаа бөгөөд нутгийн иргэд бидний хэрэглэх усны нөөц, малын бэлчээрийг давуу эрхтэй эзлэн авч хэрэглэж байгаагаас бидэнд асар их хор уршиг учруулж байна. Энэ төслийн хайгуулын ажил 2002 оноос түлхүү явагдаж 2006 оноос барилгын ажлаа эхлүүлэхдээ нутгийн иргэд бидний амьдралд ямар сөрөг нөлөөлөл үзүүлэхийг үнэлээгүй, бидэнд танилцуулаагүй үйл ажиллагаагаа эхэлсэн. Сөрөг нөлөөлөл мэдрэгдэж эхэлснээс хойш бид хандаж болох бүх газарт хандсан ч бидний эрхийг хамгаалах сонирхол, улс төрийн зориг бүхий газар олдоогүй байна.

Бид төслийн үйл ажиллагааны нөлөөлөлд дараах байдлаар өртөөд байгаа бөгөөд цаашид улам их өртөж болзошгүй байна:

1. 2004 оны нүүлгэн шилжүүлэлтийн нөлөөлөл:

Манай нутаг дэвсгэр дэх Оюу Толгой төслийн хайгуулын ажил дуусч ашиглалтын лиценз бүхий газрыг хашиж уурхай байгуулах ажил 2004 оноос эхэлсэн билээ. Ингэхдээ тус Жавхланта, Гавлиуд башийг арваннэгэн (11) өрхийг өвөлжөөнөөс нь нүүлгэн шилжүүлсэн юм. Нүүлгэсэн өрхүүдийн өвөлжөөний газар уурхайн талбайд орох, нөлөөллийн бүсэд хэт ойр орших тул ийнхүү газрыг маань авч шинэ газар сонгуулж компаниас өвөлжөө барьж байгуулах, тээврийн хэрэгсэл зардлыг гарган 2004 онд биднийг хүчээр нүүлгэсэн болно. Нэлээд олон өрх нүүхээс татгалзсан ч орон нутгийн захиргаа албадан нүүлгэлтээр далаайлган сүрдүүлсэн тул бууж өгсөн юм.

Өвөлжөө байгуулах шинэ газрыг богино хугацаанд сонгохыг тулган шаардсан тул сонголт зөв хийгдэж чадаагүй, шинэ өвөлжөөний нимгэн дэвссэн бууцны доорх газар хөлдөх магадлалыг үл харгазсанаас тэр 2004 оны зудтай өвөл ихэнх өрхүүд малаа олон тоогоор алдаж улмаар амьжиргаа доройтож эхэлсэн болно. Бидний олон үеэр эзэмшиж ирсэн өвөлжөөний бууц зузаан ултай тул доорх газар нь хөлддөггүй юм. Энэ чанар нь мал өвлийн хүйтнийг давах гол суурь нөхцөл юм. Мөн мал тарга сайн авсан байх нь хүйтэн өвлийг давах бас нэг чухал хүчин зүйл. Гэтэл уурхайн лицензтэй талбай, түүний дэд бүтцийн газарт орж бэлчээр хомсдсон. Мөн уурхайн болон замын тоосжилтод дарагдаж чанар нь доройтсон бэлчээр, ундарга нь багассан худгийн усанд ханаагүй мал тарга авч чадаагүй өвөлд орсон юм. Нүүлгэн шилжүүлэлтийн гэрээ ёсоор шинэ өвөлжөөний дэргэд гаргаж өгсөн худгуудын 3 нь л өнөөдөр ашиглагдаж байгаа. Бусад нь усгүй болсон, анхнаас нь ус гараагүй эсвэл мотор нь эвдэрсэн зэргээс нүүлгэсэн өрхүүдийн усан хангамж доройтсон тохиолдлууд олон бий.

2004 онд нүүлгэсэн нэг өрх малгүй болсон, бусад өрхийн өрхийн мал өсөөгүй, эдгээрээс 8-9 өрх шинээр мал худалдаж авах замаар амьжиргаагаа хэвийн хэмжээнд барихыг оролдож байна. Хэдий тийм боловч худгийн усны ундарга жил дараалан буурч худаг ширгэх хандлага тогтож байна. Бэлчээр хомсдох, тоосонд дарагдах зэргээс малын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж товарлаг чанараа алдаж байгаа нь бидний амьдралын түвшин улам доройтоход хүргэж байна.

2004 онд нүүлгэн шилжүүлэлтэд өртөж хохирсон 11-н өрхийн 7 өнөөдөр дахиад л Оюу Толгойн дэд бүтцийн нөлөөллийн бүсэд орж одоо нүүлгэхгүйгээр нөхөн олговор олгох хөтөлбөрт хамрагдаж давхар хохирол амсах болоод байна. Эдгээр өрхүүдийн өвөлжөө, бэлчээр нь тал талаас Оюу Толгоой төсөлд хашигдаж цаашид мал маллагаагаар амьжиргаагаа залгуулах нөхцөлгүй болж байна.

2. Нүүлгэхгүй нөхөн олговор олгохын нөлөөлөл:

250 км² асар их талбайд компанийн тооцон тогтоосноор нийт 89 малчин өрхийн өвөлжөө, мал маллагааны дэд бүтэц болох бэлчээр, хаваржаа, оторлох газрууд орж байна. Нөлөөлөлд өртөж буй

өрхүүдийг нүүлгэлгүй сөрөг нөлөөлөлд өртөж байгаад нь нөхөн олговор олгох гэрээ байгуулах ажил 2011 оноос эхэлсэн.

Гэтэл ямар нөлөөлөлд, ямар хэлбэрээр, хэдий хэмжээнд өртөж байгааг тодорхойлох аргачлал нь тодорхойгүй зөвхөн дэд бүтцэд ойрхон өвөлжөөтэй **байршлаас** хамаарсан **нэгэн өрх** гэсэн байдлаар тогтоож байна. Малчин өрх нь мал аж ахуй бүхий үйлдвэрлэгч нэгж, энэ үйлвэрлэлд буюу малчны орлого амьжиргаанд нөлөөлөх гол хүчин зүйлс нь бэлчээрийн хэмжээ, чанар, худаг усны хүртээмж, чанар болохыг хүлээн зөвшөөрөхгүй, эдгээрт учирч буй сөрөг нөлөөллийн үнэлгээ хийгдэхгүй байгааг олон малчин өрхүүд эсэргүүцэж гэрээнд гарын үсэг зурахгүй жил гаран болж байна. Харин сүүлийн саруудад элдэв арга хэрэглэж гэрээнд гарын үсэг зуруулж байна. Ингэхдээ: “Танайх ганцаараа үлдлээ шүү одоо зураагүй айлыг чигт нь хаяна”, зарим өрхүүдэд “хөдөлмөрийн бэрхшээлтэй гтэтгэмж боломжтой” эсвэл өрх толгойлсон өндөр настнуудад гэрээг уншиж танилцуулалгүй зуруулах зэрэг аргууд хэрэглэж дийлэнх өрхүүдийг гэрээнд гарын үсэг зуруулаад байна.

Ийнхүү эдийн засгийн байршлаа алдаж байгаад зохих аргачлалаар үнэлгээ хийлгүй олгох гэж байгаа нөхөн олговрын багцад багтаж байгаа олговоруудад бидний амьжиргааны түвшинг хадгалах, өсгөх боломж тусгагдаагүй байна. Үүнд:

1. *Ажлын байраар хангах* гэж байгаа нь үндсэндээ замын хог цэвэрлэх, галч, хашаач, цэвэрлэгч хийх ажлуудаас өөр мэргэжилтэй, тогтвортой, өсөх ирээдүйтэй ажил санал олгодоггүй тул ирээдүйгүй, нэр хүндгүй, мал маллагаанаас олох орлогыг нөхөх чадваргүй цалинтай ажлууд юм.
2. *Хүүхдийн сургуулийн тэтгэлэг* Гэдэгт одоо сурч байгаа хүүхдийн хичээлийн хэрэгсэлд дэмжлэг үзүүлэх. *Хүүхдийн сургуулийн хэрэгслийн хангамжид* олгогдох мөнгө нь 2004 оны гэрээний жишээнээс харвал үнийн өсөлт, хэрэглээний өсөлтийг харгалзаагүй тул хүрэлцэхгүй болдог, хүрэлцэхгүй болсон цагт тохируулга хийгддэггүй, нэр төдий олговор юм.
3. *Мөнгөн нөхөн олговор* нь юуг нөхөж байгаа, ямар аргачлалаар тооцсон, ямар хуугацаанд хэд удаа олгогдох нь тодорхойгүй тул ирээдүйд байнга өглөг харсан амьдралд тулгаж байна. Олгож байгаа мөнгөөр бичил бизнес байгуулахад тэр бүр хүрэлцэхгүй, тухайн бизнесийг эрхлэх мэргэжил, ур чадвар байхгүй, сургалт нь хангалтгүй, хоорондоо уялдаагүй байна. Мөн энэхүү мөнгөн олговор нь нөлөөлөд өртсөн өрхүүдэд олгогдох зээлтэй хэрхэн уялдаж байгаа нь тодорхойгүй байна.

Дээрх “нөхөн олговорууд” нь нөлөөлөлд өөр өөр хэмжээгээр өртөж байгаа өрхүүдийн сөрөг нөлөөллийг сааруулах, амьжиргааг нь хамгаалж чадахгүй нь өмнөх 2004 оны нүүлгэн шилжүүлэлтийн нөхөн олговрын гэрээний туршлагаас харагдаж байгаа. Мөн энэхүү гэрээнд тусгагдаагүй олон чухал асуудлууд байгаа юм. Үүнд:

Амьжиргааны эх үүсвэр бүмөсөн алдах -Яваандаа огт мал маллах боломжгүй болох өрхүүдийн амьжиргаагаа залгуулах цоо шинэ эх үүсвэр бий болгох, өөрсдөө бие даан авч явах чадавх хөгжүүлэхэд чиглэсэн байдаар шийдвэрлэх асуудал тусгагдаагүй.

Амьжиргааны түвшин хянах – амьжиргааны түвшинийг хэмжих, хамгаалах, хянах аргачлал болон хэмжилтийн үр дүнд үндэслэсэн нөхөн олговрыг хэзээ, хэдэн удаа олгогдох эсэх асуудал тусгагдаагүй.

Эрүүл мэндийн хамгаалал, түүнд учрах сөрөг нөлөөллийг сааруулах талаар нөхөн олговрын гэрээнд тусгуулах гэж яриад үр дүнд хүрээгүй болно. Тоосжилт, дуу чимээ, малаасаа авч буй мах, сүү зэрэг бүтэгдэхүүний чанарын доройтлоос бидний эрүүл мэнд ч доройтож байна. Эрүүл

мэндээр хохирч байгаад ямар нэгэн шийдэл, ялангуяа уурхайн бохирдлоос урьдчилан сэргийлэх, өөрийгөө хэрхэн хамгаалах талаар мэдээлэл ч өгөхгүй, хөтөлбөр ч байхгүй байна.

Монголын уламжлалт нүүдлийн мал маллагааны аж ахуй эрхэлж нүүдэлчин соёл иргэншлийг тээж яваа энэ нутгийн уугуулууд юм бид. Бид нүүдэллэн мал малладаг тул бэлчээрээс буюу газар ба түүний баялгаас хараат амьжиргаатай хүн ам юм. Бэлчээрийг бид уламжлалын гэх заншлаар тогтоосон хуулиар эзэмшиж ирсэн юм. Гэтэл компани бидний энэ эрхийг хүлээн зөвшөөрөхгүй, ингэхдээ ямар нэгэн бодитой үндэслэл гаргаж хэлэлцүүлээгүй болно. Биднийг үндэсний цөөнх биш тул энэ эрхийг эдлэхгүй гэж компани тайлбарладаг. Нүүдэлч хүн амын амьжиргааны эх үүсвэрийн үндсэн дэд бүтэц болох бэлчээрийн эрхийн хамгаалалт, бэлчээр алдагдсанаас амьжиргаа, уламжлалт амьдралын хэв маяг алдагдахад олгох нөхөн олговор тусгагдаагүй байна.

3. Нөхөн олговорын гэрээний өөрчлөх заалтууд:

Нөхөн олговорын гэрээний зүйл заалтуудад санал нийлэхгүй зүйлүүд тусгагдсаныг өөрчлөх санал удаа дараа гаргасан ч авч хэлэлцээгүй. Ажлын хэсгээр шийдсэн хэмээн өөрчлөхгүй байгаа. Ажлын хэсэгт нь нөлөөлөлд өртсөн өрхийн төлөөлөл 5 малчин байдаг ч хүч хүрэхгүй олонхид дийлдэх эсвэл бидний саналыг илт үл ойшоож орхигдуулсаар байна.

Гэрээний 1.2т “Малын бэлчээр шахагдсан” гэсэнд “доройтсон” гэж нэмж оруулах

1.5 “Нөхөн олговорын багцыг энэхүү гэрээний хүчинтэй хугацаанд” гэсний дараа “сар бүр” эсвэл “жил бүр” эсвэл “нэг удаа” аль болохыг тодруулж оруулж өгөх

1.6-1 Эрүүл мэнд, аюулгүй байдал, амьжиргаа залгах боломжгүй нөхцөл бүрдсэн тохиолдолд компани нүүлгэх арга хэмжээ авна. Ингэхдээ амьжиргааны бүвшин бууруулахгүй байх зарчим баритланхэрэгжүүлнэ.

1.7 Нөлөөллийг тогтоох аргачлалыг малчдын оролцоотойгоор зөвшилцөж боловсруулах

2.1.3: Малчин өрх нь зүгээр нэг өрх биш мал аж ахуйн үйлдвэрлэлийн нэгж тул дэд бүтэц нь болох бэлчээр, худаг ус нь амин чухлыг тусгаж хамгаалах.

2.1.5: “төслийн барилга болон ирээдүйд байгуулах засвар үйлчилгээний газрууд” гэж нэмэх

2.1.7: “Хүний болон малын эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөллийг” гэж нэмэх

4.1.2: Сургалтын зардлын хэсэгт “тухай жилийн үнэ өртөгт үндэслэн” гэж нэмэх

4.2: Шинээр бизнес байгуулах зардлыг тооцоход ямар аргачлал хэрэглэсэн нь тодорхоогүй байгааг тодруулж тооцоог хавсаргах.

9.1: Хасах. Энэхүү гэрэг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах аливаа хариуцлагаас чөлөөлөгдөхийг компани эрэлхийлэх нь зохисгүй. Мөн хохирол учирсан тохиолдолд нөхөн олговор авах малчдын эрхийг хорих нь зохисгүй.

10: Амьжиргааны түвшин хэмжиж байх мониторингийн аргачлалыг малчдын оролцоотой боловсруулах.


10.7: Нууцлал. Гэрээний тухай мэдээлэл хүссэн байгууллага, хувь хүмүүсийн тухай компанид мэдээлэхийг бидэнд тулгах нь зохисгүй.

Төслийн товч танилцуулга:

Оюу Толгой төслийн албан ёсны мэдээллийг тэдний www.ot.mn сайтаас татаж авч болно.

Бидэнд олгогдсон мэдээллээр Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт байршилтай Оюу Толгой алт-зэс-мөнгө олборлох уурхай нь дэлхийд гуравдугаарт орох том уурхай болох бөгөөд Монгол улсын эдийн засгийн хөгжилд асар их түлхэц өгч ДНБ-ний 30%-иар өсгөнө гэж амладаг.

Энэ төсөл хилээс 100 км газарт орших тул олборлосон бүх баялаг экспортоор БНХАУ-д гаргах, алтыг тэнд нь боловсруулж сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй гэдэг. Их хэмжээний ажлын байр бий болгоно, амьдралын түвшин нэмэгдэж Монгол улс дунд хөгжилтэй орон болно гэж амладаг. Гэтэл эдгээр нь бодит байдал дээр бууж бүтэх улс төр, эдийн засгийн нөхцөлөө бүрдүүлээгүй тул жирийн иргэд бидэнд хүртэхгүй байх магадлала нь нэмэгдсээр байгаа тухай олон эрдэмтэн мэргэжилтэн нотолж байна. Гомдол гаргагч иргэд бид уух усгүй, уламжлалт нүүдэлч амьдралаар амьдрах газаргүй, энэ эртний соёлоо үр хүүхдүүдээ уламжлуулан үлдээх боломжгүй болж байгаа нь бидний хувьд энэ төслийн бодит нөлөөлөл байна.



Оюу Толгойн ордын алт\зэсийн нөөцийн хэмжээг тохирч батлуулах ажил маргаантай байсан тул ТЭЗҮ-лээ батлуулаагүй “нөхцөлтэйгээр” хөрөнгө оруулалтын гэрээнд гарын үсэг зурсан мөн төслийн хэрэгцээний усны нөөц хангагдаагүй, оруулах хөрөнгө оруулалтын хэмжээ нь үнэн зөв тогтоогдоогүй зэрэг олон дутагдалтай мэдээлэл байгаа нь бидний сэтгэлийг түгшээж байдаг юм. Мөн дээрх газрын зураг дээр Рио Тинто\Айвенхоу Майнзын эзэмшилд буй уурхайн ба лицензтэй газрууд тэмдэглэсэн байна. Манай нутагт ийм олон уурхай төвлөрч байгаа нь бидний санааг зовоож байгаа бас нэгэн нөхцөл мөн.

Бид Гүний Хоолойн усыг, цаашид Галбын говийн усыг ашиглах, ил уурхай болон олон улсын нисэх буудлыг барих зорилгоор Ундайн голын гольдирлыг өөрлөх төлөвлөгөөг эсэргүүцсээр байгаа. Говь нутгийн усны нөөц хангалтгүй байгааг үл харгалзан энэхүү том төслийн үндэсний болон олон улсын хууль эрх зүйн зарчмуудыг зөрчин хэрэгжүүлж байгааг эсэргүүцэх тэмцлээ бид үргэлжлүүлж шаардлагатай бол энэ асуудлуудыг ч хянуулах талаар хөөцөлдөх болно. Үүний тулд бид эхний ээлжинд алдагдаж байгаа амьжиргааны эх үүсвэрээ хамгаалуулах тухай өргөдөл гаргаж байгаа юм.

Энэхүү гомдлыг бид дараах байдлаар шийдвэрлэхийг хүсч байна :

САНАЛ БОЛГОХ ШИЙДЛҮҮД

1. Нүүлгэн шилжүүлэхгүй нөхөн олговор олгох хөтөлбөрийг өмнөх 2004 оны нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговрын гэрээний хэрэгжилтийн үнэлгээний дүнд үндэслэн сайжруулах. Үүнд Оюу Толгойн Хяналт ТББ-гаас бусад ТББ-тай хамтран хийж байгаа үнэлгээний дүнг харгалзах.
2. Одоо мал маллах боломжгүй болж байгаа, уурхайн олборлолт эхэлж цаашид тэлэх явцад бэлчээрийн боломжгүй болох өрхүүдийг өөр эх үүсвэрээс амьжиргаагаа залгуулах боломж бий болгох, шинэ аж ахуй эрхлэх, мэргэжил эзэмшүүлэх, сургах зэргээр урт хугацаанд, ирээдүйд амьжиргаагаа өөрсдөө аваад явах боломж олгох байдлаар шийдэх
3. Нөхөн олговрын гэрээний зүйл заалтуудыг ганц компанийн эрх ашгийг хамгаалахаас татгалзаж талуудын эрх ашгийг эрх тэгш хамгаалах замаар хуулинд нийцүүлэх. Үүнд: гэрээний заалтуудыг өөрчлөх танай саналууд, зүй бус заалтуудыг хасах шаардлагыг хүлээж авах.

Гомдол гаргагч бид:



ОМБУДСМЭНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

**Оюу Толгой төсөлтэй холбоотой гомдол
(IFC #29007 and MIGA #7041)**

Монгол улсын Өмнөговь аймаг

2013 оны 4-р сар

*Эрх Зүйн Хяналт, Зөвлөгөө, Омбудсмэний Газар
Олон Улсын Санхүүгийн Корпораци/
Даатгалын Олон Талт Үйлчилгээний Агентлаг
www.cao-ombudsman.org*

ЭЗХЗОГ-ын тухай

Эрх Зүйн Хяналт, Зөвлөгөө, Омбудсмэний Газар (ЭЗХЗОГ) нь Дэлхийн Банкны Группын харъяа Олон Улсын Санхүүгийн Корпораци (ОУСК) болон Даатгалын Олон Талт Үйлчилгээний Агентлаг (ДОТҮА)-ийн үйл ажиллагаанд чиглэсэн хараат бус хариуцлагын механизм юм. ЭЗХЗОГ нь Дэлхийн Банкны Группын Ерөнхийлөгчид шууд тайлагнах бөгөөд ОУСК, ДОТҮА-ийн санхүүжилттэй төслийн нөлөөнд өртсөн иргэдийн гомдлыг бодитой, шударга, үр дүнтэй шийдэхэд дэмжлэг үзүүлэх, улмаар тэдгээр төслийн нийгмийн ба байгаль орчны үр нөлөөг сайжруулах чиг үүрэгтэй байгууллага болно.

Дэлгэрэнгүй мэдээллийг www.cao-ombudsman.org вэб хуудсаас үзнэ үү.

Гарчиг

Гарчиг.....	3
Товчилсон үгс.....	4
1. Хураангуй.....	5
2. Танилцуулга.....	5
2.1. Төслийн тухай.....	5
2.2. Гомдлын тухай.....	6
3. Үнэлгээ.....	7
3.1. Арга зүй.....	7
3.2. Үр дүн.....	8
3.2.1. Асуудлын тойм.....	8
3.2.2. Оролцогч талуудын зорилго, эрх ашгийн тойм.....	9
3.2.3. Дүгнэлт ба дараагийн алхмууд.....	9
Хавсралт А. ЭЗХЗОГ-ын гомдол шийдвэрлэх үйл явц.....	11

Товчилсон үгс

БМТ/ВІС	Банкны Мэдээллийн Төв
ЭЗХЗОГ/САО	Эрх Зүйн Хяналт, Зөвлөгөө, Омбудсмэний Газар
ІFC/ОУСК	Олон Улсын Санхүүгийн КорInternational Finance Corporation
ДОТҮА/МІGА	Даатгалын Олон Талт Үйлчилгээний Агентлаг
ТББ	Төрийн бус байгууллага
ОТ	Оуу Tolgoi

1. Хураангуй

ОУСК болон ДОТҮА¹ байгууллагын санхүүжилттэй Монгол улсын Өмнөговь аймагт хэрэгжиж буй Оюу Толгой төслийн нөлөөнд өртсөн орон нутгийн иргэд 2012 оны 10-р сард “Оюу Толгойн Хяналт” (үндэсний) ТББ, Ханбогд сумын “Говийн газар шороо” (орон нутгийн) ТББ-ын дэмжлэгтэй ЭЗХЗОГ-т гомдол гаргасан. ЭЗХЗОГ нь уг гомдлыг үнэлгээ хийх 3 шалгуурыг хангасан гэж үзсэн тул гомдлын үнэлгээг эхлүүлсэн. Энэхүү Үнэлгээний тайланд үнэлгээний үйл явц ба үр дүн, тухайлбал төслийн танилцуулга, гомдлын тайлбар, үнэлгээний арга зүй ба үр дүнг тоймлон толилуулав.

2. Танилцуулга

2.1. Төслийн тухай

Оюу Толгой төсөл нь Монгол улсын Өмнийн говьд орших Оюу Толгойн зэс, алтны уурхайг ашиглах зорилготой 12 тэрбум долларын хөрөнгө оруулалттай төсөл юм. Оюу Толгой ХХК-ийн хувьцааны 66%-ийг Канадад бүртгэлтэй “Turquoise Hills Resources” компани эзэмших бөгөөд үлдсэн %-ийг Монгол улсын төрийн өмчит Эрдэнэс Оюу Толгой ХХК эзэмшдэг. “Turquoise Hills Resources” компани нь Торонтогийн Хөрөнгийн Биржид хувьцаа гаргасан бөгөөд хамгийн том хувьцаа эзэмшигч нь олон улсын түвшний уул уурхайн томоохон компани болох Рио Тинто компани болно.

Тус орд нь газрын гадаргууд ойр зэс, алтны хүдрийн бөөгнөрөл (Өмнөд Оюу), далд уурхайд тохиролмжтой өндөр зэрэглэлийн орд (Хойд Хюго)-оос бүрдэнэ. Зэсийн баяжмалын үйлдвэр, холбогдох дэд бүтцийг барьж байгуулахаас эхлэн Өмнөд Оюу ил уурхайгаас голчлон хүдэр боловсруулахад чиглэсэн үе шатуудыг Төсөл хэрэгжүүлж буй. Үүнтэй зэрэгцэн Хойд Хюго ордын далд уурхайн дэд бүтэц, бүтээн байгуулалтыг хийж байна.

Төслийн өр зээл санхүүжүүлэх 4.5 тэрбум ам.долларын нэг хэсэг болгон ОУСК-ийн санал болгож буй хөрөнгө оруулалт нь ОУСК-ийн данснаас 400 сая ам.доллартай тэнцэх “А” зэргийн зээл, мөн олон улсын арилжааны банкуудтай нийлэн 1 тэрбум ам.доллар хүртэлх “Б” зэргийн зээлээс бүрдэнэ. ОУСК-ийн санхүүжилтээс гадна ДОТҮА нь хөрөнгө нийгэмчлэх, дайн ба иргэний зөрчил мөргөлдөөнийн эрсдэл, мөн 1 тэрбум ам.доллар хүртэлх зээлийн гэрээний үл биелэлтийн эрсдлээс хамгаалах баталгаа гаргах юм. Энэхүү төсөл нь Байгаль орчны А Зэрэглэлтэй.

¹ ОУСК болон ДОТҮА-ын санал болгосон төслүүдийг Дэлхийн Банк 2013 оны 2 сарын 28-нд баталсан.



Оюу Толгой төслийн байршил
Эх сурвалж: "Turquoise Hill Resources" компани

2.2. Гомдлын тухай

2012 оны 10 дугаар сард төслийн байршлын ойролцоо амьдарч, амьжиргаагаа залгуулдаг орон нутгийн нүүдэлчин малчид "Оюу Толгойн Хяналт" (үндэсний) ТББ, "Говийн газар шороо" (орон нутгийн) ТББ-ын дэмжлэгтэйгээр гомдол гаргасан.

Төсөл нь тус нутаг орны бэлчээрийн газар, усны нөөцийг ашигласнаас үүдэн малчдын нүүдлийн амьжиргааг доройтуулж, улмаар тэдний уламжлалт соёл, амьжиргаанд эрсдэл учруулж байгаад Гомдол гаргагчид санаа зовниж буйг гомдолд дурдсан. Гомдол гаргагчид нөхөн олговор болон нүүлгэн шилжүүлэлт зохих ёсоор хийгдээгүй, ялангуяа усны нөөц ховор бүс нутагт тогтвортой ус ашиглалтын асуудлыг тойрсон төслийн ажиллагаа зүй зохистой эсэхэд эргэлзэж буйгаа илэрхийлсэн.

3. Үнэлгээ

3.1. Арга зүй

ЭЗХЗОГ-ын үнэлгээний зорилго нь Гомдол гаргагчдын дурдсан тулгамдсан асуудлуудыг тодруулж тодорхойлох, тухайн нөхцөл байдлыг бусад оролцогч талууд хэрхэн үзэж байгаа талаар мэдээлэл цуглуулах, мөн Гомдолд хөндөгдсөн асуудлуудыг Гомдол гаргагчид болон Оюу Толгой компани шийдэхэд болон шийдэх арга замыг тодорхойлоход туслахад оршино.

ЭЗХЗОГ нь тус үнэлгээний явцад гомдлын асуудлыг дэмжсэн дүгнэлт гаргах мэдээлэл цуглуулаагүй. ЭЗХЗОГ-ын хийсэн гомдлын үнэлгээ нь дараахь бүрэлдэхүүн хэсгүүдээс бүрдэнэ.

- БОННУ зэрэг болон бусад төслийн баримт бичгүүдтэй танилцах
- ярилцлага, олон нийтийн болон ганцаарчилсан уулзалт, бүлгийн хэлэлцүүлэг
- Монгол улсад болон төслийн нөлөөллийн орон нутагт очиж ажилласан томилолт

ЭЗХЗОГ-ын Омбудсмэний баг нь 2012 оны 11-р сарын сүүлч, 12-р сарын эхээр Монгол улсад томилолтоор очиж ажилласан. Тус томилолтын өмнөх бэлтгэл ажил болон уг томилолтын үеэр ЭЗХЗОГ-ын томилолтын баг нь ОУСК, ДОТҮА-ийн төсөлтэй холбоотой баримт бичгүүдийг үзэж судалсан бөгөөд мөн ОУСК, ДОТҮА-ийн төслийн багууд, Ханбогд сум, багийн удирдлагатай уулзаж ярилцсан болно.

Ханбогд суманд болон төслийн байршлын орчимд орон нутгийн иргэдтэй бүлгийн ба ганцаарчилсан уулзалт ярилцлага хийсэн. Оюу Толгой төсөлд өөрсдийгөө өртсөн гэж үзэж буй нийт 82 малчид, иргэдтэй² үүний дотор 2011 оны Гэрээний ажлын хэсэг³ орсон 2 малчинтай ЭЗХЗОГ-ын багийн гишүүд уулзаж ярилцсан. Үүнд Оюу Толгойн ажлын хэсгийн бүрэлдэхүүнд багтдаг 2 малчин хамаарна. “Оюу Толгойн Хяналт” ТББ, “Банкны Мэдээллийн Төв” (BIC) байгууллагын зохион байгуулсан хамгийн том олон нийтийн уулзалт Ханбогд сумын Соёлын Төвд болсон бөгөөд үүнд орон нутгийн 60 орчим иргэд оролцсон. **Олон нийттэй хийсэн уулзалтын үеэр гомдлыг дэмжсэн 18 хувь хүний өргөдлийг САО-д нэмж** гардуулсан. ЭЗХЗОГ-ийн томилолтын баг нь малчин өрх, бэлчээр, өвөлжөө бууцанд очиж малчидтай уулзсан.

Ханбогд сум болон Улаанбаатар хот дахь Оюу Толгой компанийн ажилтнуудтай ЭЗХЗОГ-ын баг уулзсаны зэрэгцээ Оюу Толгой төслийн талбарт мөн очиж ажилласан. Оюу Толгой компанийн Орон нутгийн харилцааны хэлтсийн ажилтнууд төсөлтэй холбоотой барилгын ажил явагдаж буй төсөл хэрэгжилтийн газраар дагуулж үзүүлсэн. (үүнд усны хоолой, усны шахуургын станц, ус дамжуулах шугам г.м.)

САО мөн доор нэр бүхий засгийн газрын төлөөлөгчид болон УИХ-ын гишүүдтэй уулзав. Үүнд:

- С. Оюун, УИХ-ын гишүүн, Байгаль Орчин, Ногоон Хөгжлийн Сайд
- Б. Гантулга, БОНХЯ-ны Бодлогын Хэрэгжилтийн газрын дарга
- Л. Болормаа, Эдийн Засгийн Хөгжлийн Яамны Эдийн засгийн хамтын ажиллагаа, зээл, бодлогын газрын ахлах мэргэжилтэн

² Анхлан гомдол гаргагчид болон орон нутгийн хэд хэдэн иргэд тэдний тухай мэдээллийг нууцлах хүсэлт гаргасан.

³ Ханбогд сумын засаг даргын 2011 оны 4 сарын 14-ны тушаалаар “Ханбумбат нисэх буудал, Гашуун Сухайтын зам, цахилгаан эрчим хүчний шугам, Гүний Хоолойн шугам, зам, цахилгааны шугамын нөлөөлөлд өртсөн малчдын аж амьжиргааг дэмжих, нөлөөлийг бууруулах” ажлын хэсгийг байгуулсан.

- Д. Мөнхжаргал, Эдийн Засгийн Хөгжлийн Яамны эдийн засгийн хамтын ажиллагаа, зээл, бодлогын газрын даргын туслах
- Ч. Отгочулуу, Уул уурхайн Яамны Стратеги бодогов төлөвлөлтийн газрын дарга
- Т. Энхбаяр, Барилга Хот Байгуулалтын Яамны Сайдын Зөвлөх
- Р. Бурмаа, УИХ-ын гишүүн
- С. Ганбаатар, УИХ-ын гишүүн

ЭЗХЗГ-ын багийн гишүүд Вашингтон хот дахь ОУСК, ДОТҮА-гийн төлөөлөгчид, мөн Улаанбаатар хот дахь ОУСК-ийн Суурин төлөөлөгчийн газрын ажилтнуудтай уулзаж ярилцсан.

3.2. Үр дүн

3.2.1. Асуудлын тойм

Эхний гомдол болон ЭЗХЗОГ-ын Үнэлгээний хүрээнд хийсэн оролцогч талуудын хэлэлцүүлэгт тулгуурлан, Гомдлыг шийдвэрлэхийн тулд авч үзэх шаардлагатай гол үндсэн сэдэв, асуудлыг дор тоймлон тусгав. Үүнд:

1. Орон нутгийн иргэд болон Оюу Толгой компанийн урт хугацаанд хүсч буй хэтийн ирээдүй ямар байвал зохистой вэ? (үүнд орон нутгийн иргэд, ялангуяа бэлчээрээ алдсан малчдын амьжиргаа, байгаль орчны нөлөөлөл, бүс нутгийн болон орон нутгийн хөгжил, дэд бүтцийн хөгжил, соёлын өв г.м.)
2. Оюу Толгой компанийн хөтөлбөрүүдийг боловсруулж, хэрэгжүүлэхэд малчид хэрхэн дуу хоолойгоо илэрхийлж, оролцох вэ? (үүнд бэлчээрийн менежмент, ус ба байгаль орчны мониторинг, соёлын өв, жижиг бизнес ба эдийн засгийн хөгжил, сургалт ба чадавх бэхжүүлэх, Гүний хоолойн ажлын хэсгийн бүрэлдэхүүн ба шийдэх асуудлууд, онгоцны буудлын нөлөөлөл, Оюу Толгой – Гашуун Сухайтын зам ба цахилгааны шугам, тоосны менежмент, газрын нөхөн сэргээлт г.м.)
3. Оюу Толгой компани болон орон нутгийн оролцогч талуудын хооронд ирээдүйд харилцан зөвшилцсөн гэрээ хэлцэл байгуулах үйл явцыг хэрхэн боловсруулж хэрэгжүүлэх вэ?
4. 2004 оны Нүүлгэн шилжүүлэлтийн гэрээ болон 2011 оны Амьжиргааны нөхөн олговрын гэрээний хэрэгжилт болон хяналт мониторингын талаарх асуулт, асуудлуудыг талууд хэрхэн авч үзэж шийдвэрлэх вэ?
5. Оюу Толгой төсөлд өртсөн боловч, Оюу Толгой компаниар “өртсөн” гэж тодорхойлогдоогүй орон нутгийн малчид, иргэдтэй хэрхэн хамтарч ажиллах боломжтой эсэх?
6. Бүх оролцогч талуудад (i) мэдээлэл тогтмол өгч байх, (ii) усны найдвартай, тогтвортой хүртээмжийг хангахын тулд усны ашиглалт, нөөцний талаарх үнэн бодит, найдвартай мэдээллийг хэрхэн цуглуулж, түгээх боломжтой эсэх?
7. Малчдын болон малын эрүүл мэндэд үзүүлэх Төслийн нөлөөллийг хэрхэн хянаж шинжлэн, шийдэх вэ?
8. Ер нь Оюу Толгой компани болон орон нутгийн малчид төслийн нөлөөллийн хамрах хүрээг хэрхэн хамтран тодорхойлох, нөлөөллийг хэрхэн хэмжих боломжтой вэ?

9. Оюу Толгой компани болон орон нутгийн иргэд нийтлэг тулгамдсан асуудлаа шийдэхийн тулд хэрхэн хамтран ажиллах боломжтой вэ?

ЭЗХЗОГ-ын багийн уулзаж ярилцлага хийсэн бараг бүх оролцогч талууд олон нийт - Оюу Толгой компанийн өнөөгийн хамтын ажиллагаа, харилцаа холбоог улам сайжруулах боломжтой гэдгийг нийтлэг хүлээн зөвшөөрч байв. Түүнчлэн орон нутгийн зарим иргэд Оюу Толгой компанийн эерэг хүчин чармайлтыг үнэлж байв. (үүнд малчдын худаг барих, засахад туслах, орон нутгийн иргэдэд ажил олгох зэргийг жишээ болгон дурьдсан).

Эцэст нь малчид болон Оюу Толгой компанийн төлөөлөгчид нь тэдний соёлын ялгааны талаар дурдаж байсан. Тухайлбал нэг малчин “компанид гол нь баримт бичиг, цаас чухал. Бидэнд хүмүүсийн харилцаа, асуудлыг ярилцах нь илүү чухал” гэж хэлж байв. Иймд талууд хамтын ажиллагаагаа хэрхэн сайжруулах талаар хичээж ажиллахын зэрэгцээ харилцан итгэлцлийг бий болгон бэхжүүлэх, бие биетэйгээ үр дүнтэй харилцахын тулд эдгээр соёлын ялгааг харилцан ойлгох хэрэгтэй байж болох юм. Нэг малчин “Усыг нь увал ёсыг нь дага” гэдэг Монгол ардын зүйр үгийг иш татаж байв.

3.2.2. Оролцогч талуудын зорилго, эрх ашгийн тойм

Дээр дурдсан гол оролцогч талуудтай хийсэн хэлэлцүүлэгт тулгуурлан харвал, бүх талуудын нийтлэг хуваалцаж буй гол зорилго, эрх ашиг байгаа нь ЭЗХЗОГ-ын багт ажиглагдсан. Үүнд:

- Төсөл ОУСК, ДОТҮА-ийн стандарт, бодлогыг дагаж мөрдөж буйг баталгаажуулах
- ил тод тунгалаг байж, бүх сонирхогч талуудад Оюу Толгой төслийн талаар үнэн зөв, мэдээлэл тогтмол шуурхай өгч, мэдлэг мэдээллээр хангах замаар байгаль орчинд учруулах хор хөнөөлийг багасгах
- орон нутгийн иргэдийн уламжлалт болон соёлын эрхийг хүндэтгэн дагах
- эдийн засгийн өсөлт, орон нутгийн хөрөнгө оруулалтыг дэмжих
- Оюу Толгой компанийн төслүүд, үйл ажиллагааны талаарх чухал мэдээллийг ойлгомжтой, тодорхой, үнэн бодит, монгол хэл дээр өгч байх
- айж эмээх зүйлгүй, шударга, үр дүнтэй уур амьсгалтай уулзаж, ярилцаж байх
- олон жил цуг байх хөршүүд шиг харилцаагаа сайжруулж, итгэлцлийг бэхжүүлэх

3.2.3. Дүгнэлт ба дараагийн алхмууд

Гомдол гаргагчид болон Оюу Толгой компани нь хамтран ажиллах арга замаар Гомдолд тусгагдсан асуулдлыг шийдэх талаар ЭЗХЗОГ-ын Омбудсмэний хэлтэс/Маргаан шийдвэрлэх багтай хамтран ажиллахыг зөвшөөрсөн. ЭЗХЗОГ-ын үйл явц/журмаар талууд хэрхэн хамтран ажиллах талаар мэдээлэлд-тулгуурласан шийдвэр гаргахад нь талуудад туслах үүднээс ЭЗХЗОГ нь талуудтай уулзаж ярилцах ажлыг аль болохоор удахгүй эхлүүлнэ. Тухайлбал үүнд ЭЗХЗОГ-ын үйл явц/журмын дараахь сэдвүүд хамаарна.

- ЭЗХЗОГ-ын зохион байгуулалтын дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах үйл явцыг тодорхойлоход Талууд ямар нэр томъёо ашиглах вэ?
- Харилцан хэлэлцүүлгийн үйл явц нь ямар зорилготой вэ? Шийдвэл зохих ямар гол асуудлууд байгаа эсэх болон тэдгээрийг ямар дарааллаар шийдэх вэ? Харилцан хэлэлцүүлэг болон оролцогчдыг чиглүүлэх ямар үнэт зүйлс, зарчмууд байвал зохих вэ?

- Өөр ямар талуудтай нэмж зөвлөлдөх, оролцуулах хэрэгтэй вэ?
- Хэлцлийн ширээнд суух, шийдвэр гаргах эрх мэдэлтэй талууд хэн байх вэ? Талуудыг хэн төлөөлөх, тэдгээр хүмүүс нь шийдвэр гаргах ямар эрх мэдэлтэй байх вэ? Хэн ажиглагчаар, ямар болзолтой оролцох боломжтой вэ?
- ЭЗХЗОГ-ын туслалцаа нь хэр удаан үргэлжлэх эсэх болон уулзалтуудыг хэр зэрэг тогтмол зохион байгуулах вэ?
- Мэдээлэл харилцаа болон мэдээлэл солилцох үйл ажиллагааг хэрхэн уялдаатай зохицуулах вэ? Ямар хэл ашиглах вэ? Үйл явц/ахицыг олон нийтэд хэрхэн мэдээлэх вэ? Хэвлэл мэдээллийн хэрэгсэл (телевиз, радио, интернет, сонин сэтгүүл г.м.)-ийг ашиглах талаар талууд болон ажиглагчид ямар үүрэгтэй байх вэ?
- Шийдвэр хэрхэн гаргах вэ? Төлөөлөгчид шийдвэр гаргаж, зөвшилцөлд хүрэхэд шаардлагатай мэдээллийг холбогдох малчидтайгаа ямар хугацаанд хэлэлцэж зөвлөлдөх вэ? Харилцан зөвшилцсөн шийдвэрийг хэрхэн баримтжуулах вэ?
- Хүлээсэн үүрэг болон гэрээ хэлэлцээрийн хэрэгжилтийг хэрхэн хянаж шинжлэх вэ? Аль нэг тал хэрэгжилтийн үүргээ биелүүлээгүй тохиолдолд ямар алхмуудыг мөрдөх вэ?
- Утга учиртай, эрх тэгш оролцоог хангахын тулд техникийн мэдээлэл буюу асуудал шийдэх арга техникийн талаар ямар мэдээлэл, сургалт шаардлагатай вэ?
- ЭЗХЗОГ-ын үйл ажиллагаанд оролцож буй талууд “Өмнийн Новийн Хамтын Ажиллагааны Гэрээ”⁴ (ХАГ) – тэй үйл ажиллагаагаа хэрхэн уялдуулах вэ?

ЭЗХЗОГ-ын маргаан шийдвэрлэх үйл явцын үеэр ЭЗХЗОГ нь төвийг сахисан, зохион байгуулалтын дэмжлэг үзүүлэх бөгөөд шаардлагатай гэж үзвэл талуудтай тусдаа болон хамтарсан уулзалтууд зохион байгуулна.

⁴ “Өмнийн Говийн Хамтын Ажиллагааны Гэрээ”⁴ (ХАГ) нь орон нутгийн засаг захиргаа, засгийн газар, Монгол улс дахь хөгжлийн болон доноруудын нийгэмлэг хамтран дараахь есөн гол асуудлаар хамтран ажиллах үйл явц юм. Үүнд: 1. Ханбогдын суурин газрын хөгжил 2. Байгаль орчны хамгаалал, нөхөн сэргээлт, экологийн гэнцвэрийг хадгалах 3. Үндэсний түүх, соёл 4. Уламжлалт мал аж ахуй, бэлчээрийн зохицуулалт 5. Бэлчээр түүний орчмын газрын усны менежмент 6. Ажлаар хангах боломж, сургалт, ажил олголт 7. Орон нутаг, бүсийн засаг захиргааны чадамж, нийгмийн үйлчилгээ, боловсрол, эрүүл мэнд, дэд бүтэц, мэдээлэл 8. Орон нутгийн аж ахуйн нэгжийг хөгжүүлэх, бараа материал, үйлчилгээ, хангамж 9. Аймаг хотын хөгжил

Хавсралт А. ЭЗХЗОГ-ын гомдол шийдвэрлэх үйл явц

Эрх Зүйн Хяналт, Зөвлөгөө, Омбудсмэний Газар (ЭЗХЗОГ) нь Дэлхийн Банкны Группын харъяа Олон Улсын Санхүүгийн Корпораци (ОУСК) болон Даатгалын Олон Талт Үйлчилгээний Агентлаг (ДОТҮА)-ийн үйл ажиллагаанд чиглэсэн хараат бус хариуцлагын механизм юм. ЭЗХЗОГ нь Дэлхийн Банкны Группын Ерөнхийлөгчид шууд тайлагнах бөгөөд ОУСК, ДОТҮА-ийн санхүүжилттэй төслийн нөлөөнд өртсөн иргэдийн гомдлыг бодитой, шударга, үр дүнтэй шийдэхэд дэмжлэг үзүүлэх, улмаар тэдгээр төслийн нийгмийн ба байгаль орчны үр нөлөөг сайжруулах чиг үүрэгтэй байгууллага болно.

ЭЗХЗОГ-ын үнэлгээний зорилго нь (1) гомдол гаргагчдын дурдсан тулгамдсан асуудлуудыг тодруулж тодорхойлох, (2) тухайн нөхцөл байдлыг бусад оролцогч талууд хэрхэн үзэж байгаа талаар мэдээлэл цуглуулах, (3) гомдолд хөндөгдсөн асуудлуудыг ЭЗХЗОГ-ын Омбудсмэн болон гомдолд хамаарагч шийдэхэд болон шийдэх арга замыг тодорхойлоход туслахад оршино.

Энэхүү баримт бичиг нь ЭЗХЗОГ-ын багийн сонсож мэдсэн санал бодлын урьдчилсан тэмдэглэл бөгөөд үүнд мөн дараагийн алхмуудын тайлбарыг тусгав. *Энэхүү тайланд уг гомдлыг дэмжсэн аливаа дүгнэлт хийгээгүй болно.*

ЭЗХЗОГ-ын Үйл ажиллагааны удирдамжид⁵ тусгаснаар, тус байгууллага нь аливаа гомдол хүлээн авснаас хойш дараахь алхмуудыг ихэвчлэн хэрэгжүүлж ажилладаг.

ЭЗХЗОГ-ын Үйл ажиллагааны удирдамжид тусгасны дагуу,

1-р алхам: Гомдол хүлээн авсныг мэдэгдэх

2-р алхам: ЭЗХОГ-ын чиг үүргийн хүрээнд уг Гомдолд үнэлгээ хийх шалгуур хангасан эсэхийг тодорхойлох (15 өдрөөс хэтрэхгүй)

3-р алхам: Омбудсмэний үнэлгээ: Гомдлын асуудлуудыг үнэлэх үнэлгээ болон ЭЗХЗОГ-ын дэмжлэгт оролцоотой Талууд хамтран шийдэх боломжтой эсэх, эсвэл ОУСК, ДОТҮА-ийн нийгмийн ба байгаль орчны гүйцэтгэлийг хянан шалгах зорилгоор Гомдлыг ЭЗХЗОГ-ын Эрх зүйн хяналтын хэлтэст шилжүүлэх шаардлагатай эсэхийг оролцогч талууд тодорхойлох, тэдэнд энэ талаарх ойлголт мэдлэгийг олгоход дэмжлэг үзүүлэх. Үнэлгээний хугацаа дээд тал нь ажлын 120 өдөр хүртэл үргэлжлэх боломжтой.

4-р алхам: **Гомдлын асуудлуудыг шийдвэрлэхэд туслах:** Асуудал шийдвэрлэх аргачлалын гол зорилго нь гомдолд хөндсөн асуудлууд болон Үнэлгээний явцад буюу асуудал шийдэх явцад тодорхойлсон гомдолтой холбоотой бусад чухал асуудлыг үүнд хамааралтай талуудад хүлээн зөвшөөрөхүйц байдлаар шийдвэрлэхэд оршино⁶.

Эсвэл

Эрх зүйн хяналт/Аудит: Асуудлыг хамтран шийдэх боломжгүй тохиолдолд, ОУСК, ДОТҮА-ийн уг төсөлд оролцох оролцоо нь зохистой эсэхийг тогтоох аудит хийх

⁵ ЭЗХЗОГ-ын чиг үүрэг, үйл ажиллагааны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг ЭЗХЗОГ-ын Үйл ажиллагааны удирдамжаас <http://www.cao-ombudsman.org/about/howweare/index.html> вэб хуудаснаа бүрэн эхээр үзнэ үү.

⁶ Оролцогч талууд харилцан зөвшилцсөн хугацаандаа эв зүйгээр хамтран шийдэх арга замаар асуудлыг шийдэх боломжгүй тохиолдолд ЭЗХЗОГ-ын Омбудсмэн нь талууд уг мухардлаас гарах шийдлийг эхэлж санаачилна. Хэрэв энэ арга зам амжилтгүй болсон нөхцөлд ЭЗХЗОГ нь ОУСК, ДОТҮА-гийн холбогдох ажилтнууд, Ерөнхийлөгчид, Дэлхийн Банкны Группын Ерөнхийлөгч болон олон нийтэд мэдээлэх бөгөөд үүгээр тус гомдлыг шийдэхэд оролцох ЭЗХЗОГ-ын Омбудсмэний оролцоо дуусгавар болж, ЭЗХЗОГ-ын Эрх зүйн хяналтын хэлтэс рүү хяналт шалгалт хийлгэхээр шилжсэн болохыг тусгана.

шаардлагатай эсэхийг тогтоохын тулд Гомдолд хамааралтай төслийн талаар ОУСК, ДОТҮА-ийн хийсэн нийгмийн ба байгаль орчны судалгаа шинжилгээг ЭЗХЗОГ-ын Эрх зүйн хяналтын хэлтэс хянаж нягтлах ажлыг эхлүүлнэ.

5-р алхам: Хяналт үнэлгээ/мониторинг ба цаашдын арга хэмжээ

6-р алхам: Дүгнэлт/Хэрэг хаах



“ГОВИЙН ГАЗАР ШОРОО” ТББ

2013 он 02 сар 05 өдөр

№ 13/02

Ханбогд сум

Хатагтай Мэйган Тейлор
Нийцлийн Зөвлөх, Эрхийг Хамгаалагч (НЗЭХ)
Олон улсын санхүүгийн корпорац
2121 Pennsylvania Avenue NW
Washington, DC 20433 USA
Fax: (+1) (202) 522-7400
e-mail: cao-compliance@ifc.org

ГОМДОЛ ГАРГАХ НЬ:

Эрхэм хатагтай Тэйлор,

“Говийн газар шороо” ТББ-д нэгдэн зохион байгуулалтанд орсон Ханбогд сумын малчид бид энэхүү гомдлыг Монгол улсын Өмнөговь аймгийн Ханбогд сумын Жавхланта, Гавлиут багуудын нутаг дэвсгэрт орших Рио Тинто, Айвенхоу Майнз, Эрдэнэс МГЛ компаниудын хамтарсан Оюу Толгой ХХК –ний хэрэгжүүлж буй алт-зэс-мөнгө олборлох Оюу Толгой төсөлд холбогдуулан Олон улсын санхүүгийн корпораци (ОУСК)-ийн НЗЭХ танд хандан энэхүү гомдлыг гаргаж байна.

Монгол улсын Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт оршдог Рио Тинто, Эрдэнэс МГЛ ХХК-ийн эзэмшлийн Оюу Толгойн зэс-алтны төсөлд танай ОУСК болон Олон талт санхүүжилтийн даатгалын агентлагаас 1 тэрбум орчим зээл ба эрсдлийн баталгаа олгох асуудал идэвхтэй судлагдаж байгаа болно.

Бид Өмнөговь аймгийн Ханбогд сумын Жавхланта уугуул соёл бүхий нүүдэлч малчин өрхүүд болно. Бид Оюу Толгойн төслөөс Ундайн голын голдирлыг өөрчлөх ажлын сөрөг нөлөөлөлд өртөж амьжиргаагүй болох магадлал өндөр байгаа тул энэхүү гомдлыг гаргаж байна.

Нүүдэлчин малчид бидалслагдсан нутагт оршин суудаг, харилцаа холбоо тогтмолжоогүй, англи хэлээр шууд харилцах боломжгүйг харгалзан бид энэ гомдлыг Улаанбаатар хотод байршилтай Оюу Толгойн Хяналт ТББ-тай хамтран гаргаж танай байгууллагатай харилцах эхнийг дамжлага байхаар тохирсон болно.

Бидэнтэй дараах хаягаар холбоо барьж болно.

Л. Батцэнгэл, Говийн газар шороо ТББ-ын захирал
Хаяг: Өмнөговь аймаг, Ханбогд сум
Утас: 976-88705595, 976-99608279,
E mail: Tsengel_5595@yahoo.com;

Д. Сүхгэрэл, Оюу Толгойн Хяналт ТББ
Хаяг: СБД, Бага Тойруу, 44-6
Утас: 976- 99185828, 976- 98905828
Мэйл: otwatch@gmail.com

Нүүдэлчин малчид бид бэлчээрийн хэмжээ, чанар, усны хүртээмжээс хамааралтай амьжиргаатай болно. Энэ голын голдирлыг өөрчилснөөр Бор Овоогийн задгай ширгэж, бусад гадаргын болон хөрсний усны тэжээл алдагдаж булаг шанд, гол горхи ширгэх, бэлчээрийн ургамлын гарцад сөргөөр нөлөөлөх нь одооноос тодорхой болж байна.

2012 оны 10-р сарын 12-нд танай байгууллагад гаргасан гомдлын асуудал барагдуулаагүй байхад дээр нь нэмэгдэх асар том сөрөг нөлөөлөл гарч байна.

Бидэнд учрах сөрөг нөлөөллийг бид дараах байдлаар тодорхойлж байна

Ундайн голын голдирлыг өөрчлөхөд Бумбатын, Хөх хадны, Бугатын, Бурхантын, Хөөрхөн овоогийн, Сундуулийн, Буурлын, задгай, Будаагийн гол, Хар хадны гол, Дугатын гол, Улаан толгойн гол, горхи, Дугантын, Найман ус, Дээд хөх хад, Бор овоогийн задгай (одоо ширгэсэн байгаа) булагууд ширгэнэ. Голын урсац, хөрсөн доорхи усан тэжээл алдагдсанаас малын бэлчээрт чухал үүрэг гүйцэтгэдэг, Харгана, Хотир, Цагдуул, Буйлс, Засгал, Дэрс, Цахилдаг мэт модлог ургамал устаж үгүй болсноор энэ ургамалын үндсээр татагдсан чийгэнд тэжээгдэн ургадаг бусад Баглуур, Бударгана, Шар мод, Тэсг гэх мэт маш олон ургамал байхгүй болно.

Ундайн голыг голдирлыг өөрчилснөөс энэ гол дагуух Хар толгой, Эргэн шанд, Замын хөөвөр, Тал хармагтай, Гурван модон халив, Дугат, Буйлсан хөөвөр, Ханан даваа, Хар хад, Дөрвөлж, Улаан толгой, Хөх хад, Бор хошуу, Бумбатын улаан, Таван толгой, Салаагийн тал, Байшинт, Бурхант, Таван овоо, Наймаа ус, Хулсан, Бургасан, Пүнцэт, Зурхайч, Саглар, Шинэ ус гэх мэт газруудын бэлчээрийн чанар алдагдаж Долгорсүрэн, Намсрай, Мөнхбаяр, Баттогтох, Биндэрьяа, Батцэнгэл, Шинэбаяр, Сүрэнхорол, Идэрборгил, Энхчулуун, Цогт, Цэнп-Аюуш, Гомбосүрэн, Ширнэн, Надмид, Одгариг, Содномдорж, Төвсанаа, Алтангэрэл, Долгорсүрэн, Адъяа, Бадамзав нарын олон малчин өрхүүд амьжиргаагүй болно.

Ундайн гол нь Өмнөговь аймгийн Ханбогд сумын Гавилууд багийн нутгаас манай сумын зүүн урд зүгт нийт 200 км орчим урсаж энэ бүсийн амьдралыг тэтгэдэг гадаргын урсацбүхий ганц том гол юм. Энэ гол нь МУ-ын хамгийн нандинд тооцогддог Галбын говийн хайлас, заган ойг тэжээдэг байгалын төрөл зүйлийн нутаглах чухал ач холбогдолтой усны нөөц юм.

Ундайн гол нь мөн Чингисийн цэргүүдийг ундаалж аварсан гол гэдэг утгаар нутгийн иргэд бид амьдралыг тэтгэгч гэж тахин шүтэж, хамгаалан хайрлаж ирсэн бидний түүх соёлын ач холбогдолтой үнэт зүйлсийн нэг юм.

Ундайн голын голдирлыг өөрчлөх ажил бидний МУ-ын ба олон улсын хүний эрх зүйн баримт бичгүүдээр хамгаалагдсан дараах эрхүүдийг зөрчиж байна:

Усны эрх

Бэлчээрийн эрх

Амьжиргаатай байх эрх

Байгаль, экологийн тэнцвэр алдагдхаас хамгаалуулах

Байгалийн болон түүх соёлын өв сангаа хамгаалуулах эрх

Усгүй бол бид амьд явах баталгаа үгүй болж байгаа тул бидний зөвшөөрөлгүй дээрх эрхүүдийг зөрчиж байгаа үйлдлийг хянан шалгаж, энэ үйл ажиллагааг зогсоох арга хэмжээ авч өгөхийг нутгийн иргэд бид хүсч байна.

Бид төслийн үйл ажиллагааны нөлөөлөлд дараах байдлаар өртөөд байгаа бөгөөд цаашид улам их өртөж болзошгүй байна:

Төслийн товч танилцуулга:

Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт байршилтай ОюуТолгой алт-зэс-мөнгө олборлох уурхай нь дэлхийд гуравдугаарт орох том уурхай болох бөгөөд Монгол улсын эдийн засгийн хөгжилд асар их түлхэц өгч ДНБ-ний 30%-иар өсгөнө гэж амладаг.

Энэ төсөл хилээс 100 км газарт орших тул олборлосон бүх баялаг экспортоор БНХАУ-д гаргах, алтыг тэнд нь боловсруулах төлөвлөгөөтэй гэдэг. Их хэмжээний ажлын байр бий болгоно, амьдралын түвшин нэмэгдэж Монгол улс дунд хөгжилтэй орон болно гэж амладаг. Гэтэл бодит амьдралд хэрэгжих улс төр, эдийн засаг, усны нөөц, ажлаа хүчин гэм мэт чухал нөхцөлүүдээ бүрдүүлээгүй тул жирийн иргэд бидэнд хүртэхгүй байх магадлал нь нэмэгдсээр байгаа тухай олон эрдэмтэн мэргэжилтэн нотолж байна.

Төсөл нь өмнийн говийн усны нөөцгүй бүсэд хэрэгжих барилгын шатны ажлыг хэрэгжүүлж байгаа бөгөөд нутгийн иргэд бидний хэрэглэх усны нөөц, малын бэлчээрийг давуу эрхтэй эзлэн авч хэрэглэж байгаагаас бидэнд асар их хор уршиг учруулж байна. Энэ төслийн хайгуулын ажил 2002 оноос түлхүү явагдаж 2006 оноос барилгын ажлаа эхлүүлэхдээ нутгийн иргэд бидний амьдралд ямар сөрөг нөлөөлөл үзүүлэхийг үнэлээгүй, бидэнд танилцуулаагүй үйл ажиллагаагаа эхэлсэн. Сөрөг нөлөөлөл мэдрэгдэж эхэлснээс хойш бид хандаж болох бүх газарт хандсан ч бидний эрхийг хамгаалах сонирхол, улс төрийн зориг бүхий газар олдоогүй байна.

Гомдол гаргагч иргэд бид уух усгүй, уламжлалт нүүдэлч амьдралаар амьдрах газаргүй, энэ эртний соёлоо үр хүүхдүүддээ уламжлуулан үлдээх боломжгүй болж байгаа нь бидний хувьд энэ төслийн бодит нөлөөлөл байна.

Амьжиргааны эх үүсвэр бүмөсөн алдах -Яваандаа огт мал маллах боломжгүй болох өрхүүдийн амьжиргаагаа залгуулах цоо шинэ эх үүсвэр бий болгох, өөрсдөө бие даан авч явах чадавх хөгжүүлэхэд чиглэсэн байдаар шийдвэрлэх асуудал тусгагдаагүй.

Амьжиргааны түвшин хянах – амьжиргааны түвшинийг хэмжих, хамгаалах, хянах аргачлал болон хэмжилтийн үр дүнд үндэслэсэн нөхөн олговрыг хэзээ, хэдэн удаа олгогдох эсэх асуудал тусгагдаагүй.

Эрүүл мэндийн хамгаалал, түүнд учрах сөрөг нөлөөллийг сааруулах талаар нөхөн олговрын гэрээнд тусгуулах гэж яриад үр дүнд хүрээгүй болно. Тоосжилт, дуу чимээ, малаасаа авч буй мах, сүү зэрэг бүтэгдэхүүний чанарын доройтлоос бидний эрүүл мэнд ч доройтож байна. Эрүүл мэндээр хохирч байгаад ямар нэгэн шийдэл, ялангуяа уурхайн бохирдлоос урьдчилан сэргийлэх, өөрийгөө хамгаалах талаар мэдээлэл ч, хөтөлбөр ч байхгүй байна.

Монголын уламжлалт нүүдлийн мал маллагааны аж ахуй эрхэлж нүүдэлчин соёл иргэншлийг тээж яваа энэ нутгийн уугуулууд юм бид. Бид нүүдэллэн мал малладаг тул бэлчээрээс хараат

амьжиргаатай хүн ам юм. Бэлчээрийг бид уламжлалын гэдэг заншлаар тогтоосон хуулиар эзэмших эрх эдэлж ирсэн юм. Гэтэл компани бидний энэ эрхийг хүлээн зөвшөөрөхгүй, ингэхдээ ямар нэгэн бодитой үндэслэл гаргаж хэлэлцүүлээгүй болно. Компанийн үзэж байгаагаар бид үндэсний цөөнх биш тул энэ эрхийг эдлэхгүй гэж тайлбарладаг. Нүүдэлч хүн амын амьжиргааны эх үүсвэрийн дэд бүтэц болох бэлчээрийн эрхийн хамгаалалт, бэлчээр алдагдсанаас уламжлалт амьдралын хэв маяг алдагдахад олгох нөхөн олговор тусгагдаагүй байна.

Энэхүү гомдлыг бид дараах байдлаар шийдвэрлэхийг хүсч байна :

САНАЛ БОЛГОХ ШИЙДЛҮҮД

1. Ундайн голын голдирлыг өөрчлөх ажлыг зогсоох
2. Голын голдирлыг өөрчлөх ажлыг нутгийн хүн амын зөвшөөрөлгүй эхлүүлснээс учирсан байгаль, экологийн үйлчлэл алдагдсныг тогтоож хохирлыг барагдуулах
3. Нутгийн хүн амын усны хүртээмжийг буурулсан байдлыг тогтоож хохирлыг барагдуулах
4. 2009 оноос хойш Гүний хоолойн ус, Ундайн голын голдирлыг өөрчлөх ажиллагаагаараа бидний сэтгэл санаанд сөргөөр нөлөөлсөн хохирлыг арилгах

Гомдол гаргагч Ундайн голыг хамгаалах ажлын хэсгийн гишүүд

Б. Дугантай	—		УТХМ
Б. Уламбаяр	—		ИХ-ЫН ДЭРГЭ (БЭГИЙН)
Д. Батбаяр	—		Төвийн ерөнхий газар
О. Баттогтох	—		МАХУ
Наямаа	—		МАХУ
О. СэрОг	—		МАХУ
Нямсрэй	—		МАХУ



ОМБУДСМЭНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

**Оюу Толгой төсөлтэй холбоотой 2 дахь гомдол (Оюу Толгой-02)
(IFC #29007 and MIGA #7041)**

Монгол улсын Өмнөговь аймаг

2013 оны 7-р сар

*Эрх Зүйн Хяналт, Зөвлөгөө, Омбудсмэний Газар
Олон Улсын Санхүүгийн Корпораци/
Даатгалын Олон Талт Үйлчилгээний Агентлаг
www.cao-ombudsman.org*

ЭЗХЗОГ-ын тухай

Эрх Зүйн Хяналт, Зөвлөгөө, Омбудсмэний Газар (ЭЗХЗОГ) нь Дэлхийн Банкны Группын харъяа Олон Улсын Санхүүгийн Корпораци (ОУСК) болон Даатгалын Олон Талт Үйлчилгээний Агентлаг (ДОТҮА)-ийн үйл ажиллагаанд чиглэсэн хараат бус хариуцлагын механизм юм. ЭЗХЗОГ нь Дэлхийн Банкны Группын Ерөнхийлөгчид шууд тайлагнах бөгөөд ОУСК, ДОТҮА-ийн санхүүжилттэй төслийн нөлөөнд өртсөн иргэдийн гомдлыг бодитой, шударга, үр дүнтэй шийдэхэд дэмжлэг үзүүлэх, улмаар тэдгээр төслийн нийгмийн ба байгаль орчны үр нөлөөг сайжруулах чиг үүрэгтэй байгууллага болно.

Дэлгэрэнгүй мэдээллийг www.cao-ombudsman.org вэб хуудсаас үзнэ үү.

Гарчиг

Гарчиг.....	3
Товчилсон үгс.....	Error! Bookmark not defined.
1. Хураангуй.....	5
2. Танилцуулга	5
2.1. Төслийн тухай	5
2.2. Гомдлын тухай	Error! Bookmark not defined.
3. Үнэлгээ	6
3.1. Арга зүй	6
3.2. Үр дүн	Error! Bookmark not defined.
3.2.1. Асуудлын тойм.....	Error! Bookmark not defined.
3.2.2. Оролцогч талуудын зорилго, эрх ашгийн тойм	Error! Bookmark not defined.
3.2.3. Дүгнэлт ба дараагийн алхмууд	Error! Bookmark not defined.
Хавсралт А. ЭЗХЗОГ-ын гомдол шийдвэрлэх үйл явц.....	10

ТОВЧИЛСОН ҮГС

БМТ/ВІС	Банкны Мэдээллийн Төв
ЭЗХЗОГ/САО	Эрх Зүйн Хяналт, Зөвлөгөө, Омбудсмэний Газар
БОНБНУ/DEIA	Байгаль Орчны Нөлөөллийн Байдлын Нарийвчилсан Үнэлгээ
БОННБУ/ESIA	Байгаль Орчин Нийгмийн Нөлөөллийн Байдлын Үнэлгээ
ОУСК/IFC	Олон Улсын Санхүүгийн Корпораци
ДОТҮА/МІGА	Даатгалын Олон Талт Үйлчилгээний Агентлаг
ТББ	Төрийн бус байгууллага
ОТ	Оюу Толгой

1. Хураангуй

2013 оны 2 дугаар сард нутгийн 7 малчид ОТ Хяналт ТББ мөн орон нутгийн Говийн газар шороо ТББ-ын дэмжлэгтэйгээр Монгол Улсын Өмнөговь аймагт хэрэгжүүлж буй Оюу Толгой компанийн Ундайн голын гольдролыг өөрчлөх төслийн нөлөөллийн асуудлаар ЭЗХЗОГ-д гомдол гаргасан билээ. Тухайн үед уг төсөл ОУСК болон ДОТҮА-аас санхүүжилт авахаар хэлэлцэгдэж байсан юм¹.

2. Танилцуулга

2.1. Төслийн тухай

Оюу Толгой төсөл нь Монгол улсын Өмнийн говьд орших Оюу Толгойн зэс, алтны уурхайг ашиглах зорилготой 12 тэрбум долларын хөрөнгө оруулалттай төсөл юм. Оюу Толгой ХХК-ийн хувьцааны 66%-ийг Канадад бүртгэлтэй “Turquoise Hills Resources” компани эзэмших бөгөөд үлдсэн %-ийг Монгол улсын төрийн өмчит Эрдэнэс Оюу Толгой ХХК эзэмшдэг. “Turquoise Hills Resources” компани нь Торонтогийн Хөрөнгийн Биржид хувьцаа гаргасан бөгөөд хамгийн том хувьцаа эзэмшигч нь олон улсын түвшний уул уурхайн томоохон компани болох Рио Тинто компани болно.

Тус орд нь газрын гадаргууд ойр зэс, алтны хүдрийн бөөгнөрөл (Өмнөд Оюу), далд уурхайд тохиролмжтой өндөр зэрэглэлийн орд (Хойд Хюго)-оос бүрдэнэ. Зэсийн баяжмалын үйлдвэр, холбогдох дэд бүтцийг барьж байгуулахаас эхлэн Өмнөд Оюу ил уурхайгаас голчлон хүдэр боловсруулахад чиглэсэн үе шатуудыг Төсөл хэрэгжүүлж буй. Үүнтэй зэрэгцэн Хойд Хюго ордын далд уурхайн дэд бүтэц, бүтээн байгуулалтыг хийж байна.

“Ундай Голыг хамгаалах, Голын голдиролд хэсэгчлэн тохируулга хийх төслийн” Байгаль Орчны Нөлөөллийн Байдлын Нарийвчилсэн Үнэлгээнд (БОНБНУ) дурдсанаар:

“Ундай гол нь энэхүү төслийн талбай доторхи ач холбогдол бүхий түр урсацтай гол бөгөөд Өмнөд Оюу ил уурхайн олборлолт энэ гол хүртэл тэлж, хаягдал чулуулгийн овоолго (ХЧО) түүний сайрыг хөндлөн гарахаар төлөвлөгдсөн байна. Ундай голын голдиролын хэмжээ болон одоогийн ил уурхайг тойрох урсацыг хадгалах, үйл ажиллагаа эхэлсэн үед түүнээс үүсэх эрсдлээс (үер) зайлахын тулд түүний голдиролд хэсэгчлэн тохируулга хийж баруун салаа руу нь чиглүүлж өөрчлөх нь хамгийн оновчтой сонголт болно гэж ОТ ХХК тодорхойлсон байна. Ундай голын баруун салаа нь уурхайн ашиглалтын талбайн өмнөд хэсэгт урсах түүний үндсэн голдирол руу нийлэх юм” гэжээ:

Төслийн өр зээл санхүүжүүлэх 4.5 тэрбум ам.долларын нэг хэсэг болгон ОУСК-ийн санал болгож буй хөрөнгө оруулалт нь ОУСК-ийн данснаас 400 сая ам.доллартай тэнцэх “А” зэргийн зээл, мөн олон улсын арилжааны банкуудтай нийлэн 1 тэрбум ам.доллар хүртэлх “Б” зэргийн зээлээс бүрдэнэ. ОУСК-ийн санхүүжилтээс гадна ДОТҮА нь хөрөнгө нийгэмчлэх, дайн ба иргэний зөрчил мөргөлдөөнийн эрсдэл, мөн 1 тэрбум ам.доллар хүртэлх зээлийн гэрээний үл биелэлтийн эрсдлээс хамгаалах баталгаа гаргах юм. Энэхүү төсөл нь Байгаль орчны А Зэрэглэлтэй.

¹ ОУСК болон ДОТҮА-ын санал болгосон төслүүдийг Дэлхийн Банк 2013 оны 2 сарын 28-нд баталсан.



Оюу Толгой төслийн байршил
Эх сурвалж: "Turquoise Hill Resources" компани

2.2. Гомдлын тухай

2013 оны 2 дугаар сард нутгийн 7 малчид ОТ Хяналт ТББ мөн орон нутгийн Говийн газар шороо ТББ-ын дэмжлэгтэйгээр Оюу Толгой компанийн Ундайн голын гольдролыг өөрчлөх төслийн нөлөөллийн асуудлаар САО-д гомдол гаргасан билээ. Гомдол гаргагчдын бүрэлдэхүүнд Ханбогд сумын ИТХ-ын гишүүн, Жавхлант багийн хурлын дарга нар орсон. Гомдол гаргагчид голын гольдролыг өөрчлөх нь үндэсний уламжлалт нүүдлийн мал аж ахуй, тэдний амьжиргаанд аюул учруулна гэж үзэж байгаа бөгөөд ОТ-г голын голидрол өөрчлөх ажлаа зогсоохыг хүссэн юм. Тэд ялангуяа ийнхүү гольдрол өөрчилснөөр хэд хэдэн усан хангамжийн системийг ширгээж, бэлчээрийн үржил шимийг муутган, ой модны усан хангамжийг татруулах ба энэ голыг хүн зон тахин шүтдэг тул ёс заншилд ч нөлөөлнө хэмээн санаа нь зовниж байгаа ажээ.

3. Үнэлгээ

3.1. Арга зүй

ЭЗХЗОГ-ын үнэлгээний зорилго нь Гомдол гаргагчдын дурдсан тулгамдсан асуудлуудыг тодруулж тодорхойлох, тухайн нөхцөл байдлыг бусад оролцогч талууд хэрхэн үзэж байгаа талаар мэдээлэл цуглуулах, мөн Гомдолд хөндөгдсөн асуудлуудыг Гомдол гаргагчид болон Оюу Толгой компани шийдэхэд болон шийдэх арга замыг тодорхойлоход туслахад оршино.

ЭЗХЗОГ нь тус үнэлгээний явцад гомдлын асуудлыг дэмжсэн дүгнэлт гаргах мэдээлэл цуглуулаагүй. ЭЗХЗОГ-ын хийсэн гомдлын үнэлгээ нь дараахь бүрэлдэхүүн хэсгүүдээс бүрдэнэ.

- БОННУ зэрэг болон бусад төслийн баримт бичгүүдтэй танилцах
- ярилцлага, олон нийтийн болон ганцаарчилсан уулзалт, бүлгийн хэлэлцүүлэг
- Монгол улсад болон төслийн нөлөөллийн орон нутагт очиж ажилласан томилолт.

ЭЗХЗОГ-ын Омбудсмэний баг нь гомдлыг хүлээн авсны дараа 2013 оны 2 ба 3-р сард Монгол улсад томилолтоор очиж ажилласан. Тус томилолтын өмнөх бэлтгэл ажил болон уг томилолтын үеэр ЭЗХЗОГ-ын томилолтын баг нь ОУСК, ДОТҮА-ийн төсөлтэй холбоотой баримт бичгүүдийг үзэж судалсан бөгөөд мөн ОУСК, ДОТҮА-ийн төслийн багууд, Ханбогд сум, багийн удирдлага болон орон нутгийн иргэдтэй уулзаж ярилцсан болно.

Ханбогд сум болон Улаанбаатар хот дахь Оюу Толгой компанийн ажилтнуудтай ЭЗХЗОГ-ын баг уулзсаны зэрэгцээ Оюу Толгой төслийн талбарт мөн очиж ажилласан. Оюу Толгой компанийн Орон нутгийн харилцааны хэлтсийн ажилтнууд төсөлтэй холбоотой барилгын ажил явагдаж буй төсөл хэрэгжилтийн газраар дагуулж үзүүлсэн.

САО мөн доор нэр бүхий засгийн газрын төлөөлөгчид болон УИХ-ын гишүүдтэй уулзав. Үүнд:

- С. Оюун, УИХ-ын гишүүн, Байгаль Орчин, Ногоон Хөгжлийн Сайд
- Б. Гантулга, БОНХЯ-ны Бодлогын Хэрэгжилтийн газрын дарга
- Л. Болормаа, Эдийн Засгийн Хөгжлийн Яамны Эдийн засгийн хамтын ажиллагаа, зээл, бодлогын газрын ахлах мэргэжилтэн
- Д. Мөнхжаргал, Эдийн Засгийн Хөгжлийн Яамны эдийн засгийн хамтын ажиллагаа, зээл, бодлогын газрын даргын туслах
- Ч. Отгочулуу, Уул уурхайн Яамны Стратеги бодогов төлөвлөлтийн газрын дарга
- Т. Энхбаяр, Барилга Хот Байгуулалтын Яамны Сайдын Зөвлөх
- Р. Бурмаа, УИХ-ын гишүүн
- С. Ганбаатар, УИХ-ын гишүүн

ЭЗХЗГ-ын багийн гишүүд Вашингтон хот дахь ОУСК, ДОТҮА-гийн төлөөлөгчид, мөн Улаанбаатар хот дахь ОУСК-ийн Суурин төлөөлөгчийн газрын ажилтнуудтай уулзаж ярилцсан.

3.2. Үр дүн

3.2.1. Асуудлын тойм

Эхний гомдол болон ЭЗХЗОГ-ын Үнэлгээний хүрээнд хийсэн оролцогч талуудын хэлэлцүүлэгт тулгуурлан, Гомдлыг шийдвэрлэхийн тулд авч үзэх шаардлагатай гол үндсэн сэдэв, асуудлыг дор дурдав. Үүнд:

1. Ундай Голын нөлөөллийн талаар талууд хэрхэн харилцан нэгдмэл ойлголттой болж болох, голдирол өөрчлөх төслийн загвар дизайн нөлөөллийг хэрхэн бууруулж/ эсвэл нөлөөллөөс хэрхэн урьдчилан сэргийлэх вэ?

2. ОТ-ийн тодорхойлоогүй байгаа нэмэлт ямар нөлөөлөл байна, тэдгээр нөлөөллийг бууруулах эсвэл шийдвэрлэхийн тулд юу хийж болох вэ?

Ундайн голын гольдролыг өөрчлөхийн тулд орон нутгийн иргэдийн санал, зөвшөөрлийг авах ёстой гэж гомдол гаргагчид үзэж байгаа ба харин ОТ өөрийн төслийн лицензтэй талбайд буй голын хэсгийг өөрчлөх бүх хууль ёсны лиценз, зөвшөөрөлтэй (орон нутгийн иргэдийн саналыг төрөл бүрийн зөвлөлдөх үйл ажиллагаагаар авч нөлөөллийг бууруулах, загвар дизайны төлөвлөгөөндөө тусгаж байсан) гэж байгаа юм. Уурхайн лицензтэй талбайгаас гадна баригдах төслийн хэсгийг барьж байгуулахад орон нутгийн Засаг даргаас зөвшөөрөл авах ёстой гэдгийг ОТ баталгаажуулж байгаа бөгөөд улмаар төслийн энэ хэсгийг барьж байгуулах ажил хийгдэж эхлээгүй байна. Гомдол гаргагчид орон нутгийн иргэдийн зөвшөөрлийг автал голын гольдролыг өөрчлөхтэй холбоотой бүх барилга байгууламжийн ажлыг зогсоох ёстой гэсэн албан ёсны байр суурьтай байхад ОТ голыг болон уурхайг хамгаалахын тулд ажлыг үргэлжлүүлэх ёстой гэлээ. Гэсэн хэдий ч талууд ЭЗХЗОГ - ы маргаан шийдвэрлэх дамжлагын дагуу гомдлыг харилцан ашигтай байдлаар шийдвэрлэхэд хамтран ажиллахаар тохирлоо.

3.2.2. Оролцогч талуудын зорилго, эрх ашгийн тойм

Дээр дурдсан гол оролцогч талуудтай хийсэн хэлэлцүүлэгт тулгуурлан харвал, талууд дараах гол зорилго, эрх ашгийг эрэлхийлж байгаа нь ЭЗХЗОГ-ын багт ажиглагдсан. Үүнд:

Гомдол гаргагч/Малчдын зорилго, эрх ашиг:

- Хүн, мал, ан амьтныг ундны усаар хангах
- Нутгийн малчдад учирсан аливаа хохирлыг засч залруулах
- Төслийн тухай үнэн бодит мэдээллийг ойлгомжтой байдлаар авах
- Бор овооны ариун дагшин байдал, соёлын үнэт байдлыг хүндэтгэх
- Бэлчээрийг усгүйдэж доройтохоос хамгаалах
- Бор Овоогийн задгай өвөл хожуу хөлддөг экологийн үйлчлэлийг хүртэх
- Нөлөөлөлд өртсөн бүх малчдын хууль ёсны эрхийг хүндэтгэх

Оюу Толгойн зорилго, эрх ашиг:

- Ил уурхай руу ус алдахаас сэргийлэх
- Нутгийн малчдыг хүрэлцээтэй устай байлгах
- Бодит нөлөөлөл, нөлөөллийг бууруулах арга хэмжээний талаар олон нийтэд байнга мэдээлэх
- Төслийг цаг хугацаанд нь багтаан урагшлуулах/хугацаа хойшлохыг багасгах
- Үйл ажиллагаагаа "нийгмийн зөвшөөрөл"-тэй явуулах (орон нутгийг дэмжиж сайн харилцаатай байх)

- Малчдын төлөөлөгчид болон нийт малчид, иргэдийн хоорондын үр нөлөөтэй бүтээлч харилцаа холбоог тусалж дэмжих

Хамтын зорилго, эрх ашиг:

- Ундай голыг хамгаалах
- Орон нутгийн малчдад үзүүлсэн сөрөг нөлөөллөөс урьдчилсан сэргийлэх эсвэл сөрөг нөлөөллийг бууруулах
- Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилсан сэргийлэх эсвэл сөрөг нөлөөллийг бууруулах
- Монгол Улсын хууль тогтоомж болон ОУСК-ын Гүйцэтгэлийн Стандартыг дагаж мөрдөх

3.2.3. Дүгнэлт ба дараагийн алхмууд

Гомдолд тусгасан асуудлуудыг хамтын чармайлтаар шийдвэрлэхийн тулд гомдол гаргагчид ба ОТ ЭЗХЗОГ-ны Маргаан шийдвэрлэх багтай хамтран ажиллахаар тохирлоо. Гомдол гаргагчид бусад малчид болон ЭЗХЗОГ-д гаргасан эхний гомдолд (Оюу Толгой-01)² гарын үсэг зурсан талуудтай хүчээ нэгтгэн, ЭЗХЗОГ болон ОТ-той ажиллах малчдын төлөөллийг сонгон, хоёр гомдлыг хамтад нь шийдвэрлэхээр ажиллаж байна.

ЭЗХЗОГ-ны маргаан шийдвэрлэх ажиллагааны үеэр ЭЗХЗОГтөвийн сахисан эвлэрүүлэн зуучлах/чиглүүлэх ажлыг хийж байгаа ба шаардлагатай тохиолдолд тус тусад нь болон хамтарсан уулзалтуудыг хийж байна. ЭЗХЗОГ уулзалтуудын хугацаа, үйл явц, хуваарь гаргах тухай тохиролцоход нь талуудад туслалцаа дэмжлэг үзүүлнэ.

² Эхний гомдлын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг http://www.cao-ombudsman.org/cases/case_detail.aspx?id=191-aac үзнэ үү.

Хавсралт А. ЭЗХЗОГ-ын гомдол шийдвэрлэх үйл явц

Эрх Зүйн Хяналт, Зөвлөгөө, Омбудсмэний Газар (ЭЗХЗОГ) нь Дэлхийн Банкны Группын харъяа Олон Улсын Санхүүгийн Корпораци (ОУСК) болон Даатгалын Олон Талт Үйлчилгээний Агентлаг (ДОТҮА)-ийн үйл ажиллагаанд чиглэсэн хараат бус хариуцлагын механизм юм. ЭЗХЗОГ нь Дэлхийн Банкны Группын Ерөнхийлөгчид шууд тайлагнах бөгөөд ОУСК, ДОТҮА-ийн санхүүжилттэй төслийн нөлөөнд өртсөн иргэдийн гомдлыг бодитой, шударга, үр дүнтэй шийдэхэд дэмжлэг үзүүлэх, улмаар тэдгээр төслийн нийгмийн ба байгаль орчны үр нөлөөг сайжруулах чиг үүрэгтэй байгууллага болно.

ЭЗХЗОГ-ын үнэлгээний зорилго нь (1) гомдол гаргагчдын дурдсан тулгамдсан асуудлуудыг тодруулж тодорхойлох, (2) тухайн нөхцөл байдлыг бусад оролцогч талууд хэрхэн үзэж байгаа талаар мэдээлэл цуглуулах, (3) гомдолд хөндөгдсөн асуудлуудыг ЭЗХЗОГ-ын Омбудсмэн болон гомдолд хамаарагч шийдэхэд болон шийдэх арга замыг тодорхойлоход туслахад оршино.

Энэхүү баримт бичиг нь ЭЗХЗОГ-ын багийн сонсож мэдсэн санал бодлын урьдчилсан тэмдэглэл бөгөөд үүнд мөн дараагийн алхмуудын тайлбарыг тусгав. *Энэхүү тайланд уг гомдлыг дэмжсэн аливаа дүгнэлт хийгээгүй болно.*

ЭЗХЗОГ-ын Үйл ажиллагааны удирдамжид³ тусгаснаар, тус байгууллага нь аливаа гомдол хүлээн авснаас хойш дараахь алхмуудыг ихэвчлэн хэрэгжүүлж ажилладаг.

ЭЗХЗОГ-ын Үйл ажиллагааны удирдамжид тусгасны дагуу,

1-р алхам: **Гомдол хүлээн авсныг мэдэгдэх**

2-р алхам: **Шалгуур хангасан эсэх:** ЭЗХЗОГ-ын чиг үүргийн хүрээнд уг Гомдолд үнэлгээ хийх шалгуур хангасан эсэхийг тодорхойлох (15 өдрөөс хэтрэхгүй)

3-р алхам: **Омбудсмэний үнэлгээ:** Гомдлын асуудлуудыг үнэлэх үнэлгээ болон ЭЗХЗОГ-ын дэмжлэгт оролцоотой Талууд хамтран шийдэх боломжтой эсэх, эсвэл ОУСК, ДОТҮА-ийн нийгмийн ба байгаль орчны гүйцэтгэлийг хянан шалгах зорилгоор Гомдлыг ЭЗХЗОГ-ын Эрх зүйн хяналтын хэлтэст шилжүүлэх шаардлагатай эсэхийг оролцогч талууд тодорхойлох, тэдэнд энэ талаарх ойлголт мэдлэгийг олгоход дэмжлэг үзүүлэх. Үнэлгээний хугацаа дээд тал нь ажлын 120 өдөр хүртэл үргэлжлэх боломжтой.

4-р алхам: **Гомдлын асуудлуудыг шийдвэрлэхэд туслах:** Асуудал шийдвэрлэх аргачлалын гол зорилго нь гомдолд хөндсөн асуудлууд болон Үнэлгээний явцад буюу асуудал шийдэх явцад тодорхойлсон гомдолтой холбоотой бусад чухал асуудлыг үүнд хамааралтай талуудад хүлээн зөвшөөрөхүйц байдлаар шийдвэрлэхэд оршино⁴.

Эсвэл

Эрх зүйн хяналт/Аудит: Асуудлыг хамтран шийдэх боломжгүй тохиолдолд, ОУСК, ДОТҮА-ийн уг төсөлд оролцох оролцоо нь зохистой эсэхийг тогтоох аудит хийх

³ ЭЗХЗОГ-ын чиг үүрэг, үйл ажиллагааны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг ЭЗХЗОГ-ын Үйл ажиллагааны удирдамжаас <http://www.cao-ombudsman.org/about/howweare/index.html> вэб хуудаснаа бүрэн эхээр үзнэ үү.

⁴ Оролцогч талууд харилцан зөвшилцсөн хугацаандаа эв зүйгээр хамтран шийдэх арга замаар асуудлыг шийдэх боломжгүй тохиолдолд ЭЗХЗОГ-ын Омбудсмэн нь талууд уг мухардлаас гарах шийдлийг эхэлж санаачилна. Хэрэв энэ арга зам амжилтгүй болсон нөхцөлд ЭЗХЗОГ нь ОУСК, ДОТҮА-гийн холбогдох ажилтнууд, Ерөнхийлөгчид, Дэлхийн Банкны Группын Ерөнхийлөгч болон олон нийтэд мэдээлэх бөгөөд үүгээр тус гомдлыг шийдэхэд оролцох ЭЗХЗОГ-ын Омбудсмэний оролцоо дуусгавар болж, ЭЗХЗОГ-ын Эрх зүйн хяналтын хэлтэс рүү хяналт шалгалт хийлгэхээр шилжсэн болохыг тусгана.

шаардлагатай эсэхийг тогтоохын тулд Гомдолд хамааралтай төслийн талаар ОУСК, ДОТҮА-ийн хийсэн нийгмийн ба байгаль орчны судалгаа шинжилгээг ЭЗХЗОГ-ын Эрх зүйн хяналтын хэлтэс хянаж нягтлах ажлыг эхлүүлнэ.

5-р алхам: **Хяналт үнэлгээ/мониторинг** ба цаашдын арга хэмжээ

6-р алхам: **Дүгнэлт/Хэрэг хаах**